

АВЛИГЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ДҮН (ХУРААНГУЙ)

Бүлэг 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар (цаашид АТГ гэнэ) нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлэгийг хянан шилгах чиг үүрэг бүхий хараат бус бие даасан, төрийн тусгай байгууллага юм. Түүнчлэн Авлигын эсрэг Монгол Улсын хуульд заасны дагуу Авлигын цар хүрээ, цар хүрээ, хэлбэр шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индекс болон төрийн байгууллагын шударга байдлыг түвшинг судлан олон нийтэд мэдээлэх үүргийг хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 2008 оны 3 дугаар сард АТГ-т Судалгаа, шинжилгээ алба (цаашид США гэнэ)-ыг байгуулсан. США байгуулагдснаар үндэсний болон олон түвшинд авлигын чиглэлээр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлуудын аргачлал, арга зүй, үр дүн, тэдгээрт хийгдсэн дүгнэлт зэргийг судлан үзэж улмаар Авлигын индекс, төрийн байгууллагын шударга байдлын түвшинг тогтоох судалгааны аргачлал, арга зүйг боловсруулах зэрэг ажлыг хийж ирсэн юм.

Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын 2005 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 25 дугаар тогтоолоор “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд”-ыг баталсан билээ. Энэхүү тогтоолоор Монгол Улс Нэгдсэн үндэстний байгууллагын дээд хэмжээний уулзалтаас (2000 оны 9 дүгээр сар, АНУ, Вашингтон) гаргасан “Мянганы тунхаглал” дахь Мянганы хөгжлийн зорилго (МХЗ)-ын найман зорилт дээр нэмж “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” гэсэн 9 дэх зорилгыг шинээр баталсан юм. Монгол Улсын дэвшүүлсэн мянганы хөгжлийн ес дэх зорилгын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох чиглэлээр НҮБ-ын Ардчиллын сангаас Мянганы хөгжлийн 9 дэх зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төслийг санхүүжүүлэн Шинжлэх ухааны академийн Философи, социологи эрхийн хүрээлэн ажилласан. Уг ажлын хүрээнд мянганы хөгжлийн ес дэх зорилгын хүрээнд 12 шалгуур үзүүлэлтийг тодорхойлон 2008 оны 1 дүгээр сарын 1 дүгээр сарын 31-ний өдрийн УИХ-ын 13 дугаар тогтоолоор Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн баталсан. Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” гэсэн 24 дүгээр зорилтын хүрээнд дараах 3 үзүүлэлт багтаж байгаа юм. Үүнд:

- Авлигын индекс
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл
- Төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл зэрэг юм.

УИХ-ын 2008 оны 13 тогтоолын дагуу дээрх гурван шалгуур үзүүлэлтийн Авлигын индекс болон улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл гэсэн хоёр төрлийн үзүүлэлтийг АТГ тооцож мэдээлэхээр болсон билээ.

Дээрх үндэслэл, шаардлагын хүрээнд авлигын индексийг тооцох аргачлалыг боловсруулах чиглэлээр олон улсын болон дотоодын зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд уг ажлын суурь мэдээллийг цуглуулах зорилгоор авлигын талаарх төсөөлөл, цар хүрээ, хэлбэр шалтгааныг тодорхойлох зорилготой судалгааг иргэд, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчид гэсэн гурван чиглэлээр Монгол Улсын бүх аймаг, нийслэлийг хамруулан явууллаа.

1.2 Судалгааны зорилго

Энэ удаагийн судалгааны зорилго нь иргэд, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчдийн авлигын талаарх төсөөлөл, авлигын цар хүрээ, хэлбэр шалтгаан, тэдгээрийг хэрхэн арилгах талаарх тэдний санаа бодлыг тодруулах, авлигатай холбоотой тэдэнтэй тохиолдож байсан асуудлууд, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэж байсан зэрэг мэдээллийг цуглуулан, нэгтгэн дүгнэж олон нийтэд тархах, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийн суурь мэдээлэл болгон ашиглах явдал юм.

Нөгөө талаас авлигын индексийн аргачлалыг боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, энэ чиглэлээр судалгаа явуулах туршлага хуримтлуулахад энэ удаагийн судалгааны зорилго оршиж байгаа юм.

1.3 Судалгааны хамрах хүрээ

Авлигын талаарх тандалтын судалгааны хамрах хүрээг гурван бүлэгт авч үзсэн. Үүнд:

1. Иргэд (Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршиж суугаа иргэд)
2. Төрийн албан хаагчид (“Төрийн албаны тухай” Монгол Улсын хуулийн 3.3-д заасан төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчид)
3. Бизнес эрхлэгчид (Ашгийн төлөө бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг өмчийн бүх төрлийн хуулийн этгээдийн захирал, эзэн болон аж ахуйн зохион байгуулалтад ороогүй хувиараа хөдөлмөр эрхлэгчид)

Газар зүйн байршилын хувьд судалгааны хамрах хүрээ нь Монгол Улсын бүх газар нутаг байв.

1.4 Судалгааны ерөнхий зарчим, зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалт

Авлига бол олон талт нийгмийн үзэгдэл бөгөөд түүнийг цөөн үзүүлэлтээр тодорхойлох боломжгүй юм. Энэ удаагийн судалгааны зорилго нь манай улсад оршиж буй авлигын энэхүү олон талт дүр зургийг тодорхойлох зорилготой бөгөөд авлигыг субъектив болон объектив хоёр талаас авч үзсэн юм. Авлигын субъектив бүрэлдэхүүн хэсэгт дараахь асуудлыг хамруулж үзсэн. Үүнд:

1. Тухайн орон нутаг дахь авлигын түвшин.
2. Авлигад хандах хандлага
3. Авлигын талаарх ойлголт тодорхойлолт

Авлигын объектив бүрэлдэхүүн хэсэгт дараахь асуудлыг хамруулж үзсэн.

Үүнд:

1. Судалгаанд оролцогчдын амьдралын хэв маяг
2. Авлигын тархалтын үзүүлэлтүүд
3. Авлигатай холбоотой туршлагын үзүүлэлтүүд
4. Авлигын үр дагавар

Дээрх субъектив болон объектив талын талаарх мэдээллийг цуглуулахад чиглэгдсэн санал асуулгын хуудсыг нийгмийн тодорхой бүлгүүдээр бөглүүлэн авч нэгтгэн дүгнэх замаар судалгааг явуулсан.

Судалгааны мэдээллийг санал асуулга гэдэг утгаар сайн дурын үндсэн дээр цуглуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2008 оны 9-11 сард АТГ-аас зохион байгуулсан “Аймаг, сум алслагдсан дүүрэгт зохион байгуулах ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд гүйцэтгэлээ.

Иргэдийн судалгааны мэдээллийг сонгогдсон багийн Засаг дарга, хорооны хэсгийн ахлагч нараар нийт өрхүүдэд тараан өгч бөглүүлсэн.

Төрийн албан хаагчдын судалгааны мэдээллийг сонгогдсон төрийн байгууллагын албан хаагчдад тараан өгч бөглүүлсэн.

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос “Аймаг, сум, алслагдсан дүүрэгт зохион байгуулах ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд “Ажил олгогч эзэд, бизнес эрхлэгчид авлигын эсрэг” сэдэвт сургалтыг зохион байгуулсан бөгөөд энэхүү сургалт, семинарын явцад оролцогчдын дунд энэ чиглэлээр хэлэлцүүлэгийг зохион байгуулж, судалгааны хуудсыг бөглүүлсэн.

1.5 Судалгааны хугацаа

Энэхүү судалгаа нь нэг удаагийн түүвэр судалгаа байсан бөгөөд судалгааны мэдээллийг 2008 оны 9 дугаар сарын 8-наас 11 дүгээр сарын 19-нийг хүртэлх хугацаанд цуглуулсан.

1.6 Судалгааны түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийг хоёр түвшинд хийсэн. Түүвэрлэлтийн эхний шатанд аймаг тус бүрээс судалгаанд хамрагдах сумдыг сонгосон. Энэ аймгийн төвийн сумдыг нэлэнхүй байдлаар бүгдийг нь, бусад сумдаас хүн амын тоо, нягтрал зэргийг харгалзан үзэж сонгосон. Судалгааны түүвэрлэлтийн хоёрдахь шатанд судалгаанд хамрагдах нэгжийг сонгосон.

Судалгааны **түүвэрлэлтийн нэгж нь хувь хүн юм**. Тухайлбал, бизнес эрхлэгчдийн судалгааны хувьд ашгийн төлөө бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг өмчийн төрлийн хуулийн этгээдийн захирал, эзэн болон аж ахуйн зохион байгуулалтад ороогүй хувиараа хөдөлмөр эрхлэгчид байсан бөгөөд тэд бизнесийн нэгжийн болоод хувь хүнийхээ хувьд судалгааны асуулгад хариулж байсан юм.

Иргэд, төрийн албан хаагчдын судалгааны хувьд судалгаанд хамрагдах нэгжийг энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгосон. Бизнес эрхлэгчдийн судалгаанд Ажил олгогч эздийн холбооны аймаг орон нутаг дахь салбарт бүртгэлтэй бизнес эрхлэгчдийг хамруулсан.

1.7 Судалгааны асуулгын хуудас

Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээг харгалзан судалгааны асуулгыг боловсруулахдаа ОХУ-ын ИНДЕМ (INDEM – Information Science for Demography) байгууллагын Авлигын талаарх судалгаанд ашигладаг асуулгын хуудсын ерөнхий загварт үндэслэн Монгол Улсын онцлог зэргийг тусган боловсруулсан.

Индем нь 1990 онд байгуулагдсан, Оросын анхны төрийн бус байгууллагуудын нэг юм. Индем нь Орос улсын төрийн байгууллага, албан хаагчдад иргэний нийгэм, зөвлөхүүдийн туслалцаатайгаар ардчиллын үзэл санаа, үнэт зүйлсийг дэлгэрүүлэх зорилготой бөгөөд түүний үйл ажиллагаа нь авлигын эсрэг, хууль зүйн туслалцаа, засаглалын шинэтгэл, улс төрийн, угсаатны, холбооны улсын болон бүс нутгийн асуудлууд, олон улсын хамтын ажиллагаа зэрэг өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Судалгааны зориулалтаар Индем социологийн, статистикийн, мэдээллийн технологийн чухал аргуудыг боловсруулж ирсэн.

Санал асуулгын хуудасны бүтэц нь судалгаанд оролцогч гурван бүлгээс нийтлэг байдлаар асууж үр дүнг гарган харьцуулах зорилго бүхий ерөнхий хэсэг болон иргэд, төрийн албан хаагчид болон бизнес эрхлэгчдэд зориулсан тусгай хэсэг гэсэн хоёр хэсгээс бүрдэж байсан юм.

Санал асуулгын ерөнхий хэсэгт дараахи асуудлуудыг агуулж байв.
Үүнд:

- Үнэлгээ: ерөнхийд нь авлигын түвшин, авлигад автсан байдлаар нь, авлигын төрлүүдээр нь гэх мэтээр төрөл бүрийн төрийн байгууллагуудын эрх мэдлийн харьцуулалт.
- Ойлголт: авлига болон түүнийг бий болгож буй шалтгаан нөхцлийн талаарх ойлголттой холбоотой бүлэг асуултууд
- Итгэлцэл: “Илтгэх-үл илтгэх” гэсэн төрөлд судалгаанд оролцогчдыг тодорхойлж хамруулах зорилго бүхий бүлэг асуултууд
- Авлигад автах -үл автах байдал: Авлигын хэлэлцээрт оролцоход бэлэн байдал болон авлигын эсрэг байх байдлаар нь хариулагч нарыг тодорхойлох бүлэг асуултууд

- Зан төлөв: хариулагч нарын үйл хөдлөл, үнэлгээнд нөлөөлж болох тэдний нийгэм-сэтгэл зүйн зан төлөвийг олон талаас нь тодорхойлох бүлэг асуултууд
- Авлигын эсрэг арга хэмжээ болон энэхүү төрлийн асуудлуудын талаархи санаа бодол
- Улс төр: хариулагч нарын улс төрийн үзэл бодлыг илэрхийлэх бүлэг асуултууд
- Нийгэм-хүн ам зүйн асуултууд
- Судалж буй тухайн асуудлыг шийдвэрлэх бусад асуултууд

Иргэдэд зориулагдсан асуултуудын тусгай хэсэгт дараахь асуултуудыг авч үзсэн. Үүнд:

- Хариулагчдын нийгмийн оролцооны талаархи өөрсдийнх нь үнэлгээ
- Ахуйн хүрээн дэх авлигын хэмжээ, шинж чанарын талаарх ерөнхий үнэлгээ
- Хамгийн сүүлд учирсан авлигын тохиолдлынх нь талаархи асуултууд
- Улсын болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын үйлчилгээний талаарх ерөнхий үнэлгээ
- Улсын болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын үйлчилгээнд авлигатай учирсан тохиолдлууд

Бизнес эрхлэгчдийн судалгааны асуулга нь дараахь сэдвийг хамарсан бүлэг асуултуудтай байсан. Үүнд:

- Эрхэлж буй бизнесийн талаархи үзүүлэлтүүд /цар хэмжээ, салбар, өмчлөлийн хэлбэр гэх мэт/
- Бизнесийн үйл ажиллагааны авлигад өртсөн байдал
- Бизнесийн ололт амжилт
- Тендерт оролцох зэрэг бизнесийн төртэй болон шүүхийн байгууллагуудтай харилцах харилцаа
- Бизнесийн төрөөс хамаарах хамаарал
- Төрөөс бизнест үзүүлж буй дарамт шахалт
- Авлига, хээл хахууль болон бусад албан бус арга хэмжээ: туршлага, нөхцөл, үр нөлөө

Төрийн албан хаагчдын судалгааны асуулгын хувьд 1999 онд Голландын хамтын ажиллагааны банкнаас санхүүжүүлэн Бангладеш улсад явуулсан “Төрийн албан хаагчдын авлигын түвшин, тохиолдлууд” судалгааны асуулгад үндэслэн боловсруулсан.

Төрийн албан хаагчдын судалгааны асуулга нь дараахь хэсгүүдээс бүрдэж байв. Үүнд:

- Төрийн албанд хэрхэн орсон

- Төрийн албаны боломж, давуу тал
- Төрийн албаны үйл ажиллагаан дахь ил тод байдал
- Төрийн албаны үйл ажиллагаан дахь авлигатай холбоотой нөхцөл, тохиолдлууд
- Авлигын талаарх мэдээлэл, мэдлэг

1.8 Мэдээллийн нууцлал

Судалгааны асуулгаар цуглуулагдаж буй мэдээлэл нь авлига, хүнд сурталтай холбоотой хувь хүний үзэл бодол бөгөөд судалгаанд хамрагчдын мэдээллийн нууцлалыг хамгаалж судалгаанд хамрагдагчид асуулганд бодитой, үнэн зөв мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлэх нь судалгааны үр дүнд чухал үр нөлөөтэй байсан юм. Энэ зорилгоор судалгааны асуулгыг нэр, хаяггүйгээр бөглүүлэн авсан. Энэхүү судалгаагаар цуглуулсан мэдээллийг авлигын цар хүрээ, хэлбэр шалтгааныг тодорхойлон төр засгаас хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэж, бодлого боловсруулахад ашиглаж, мөрдөн байцаалт болон бусад зорилгоор хэрэглэхгүй байх болно гэдгийг судалгаанд хамрагсдад таниулан ойлгуулсан.

1.9 Мэдээлэл боловсруулалт

Судалгааны мэдээллийг оруулах загварыг АНУ-ын Тооллогын товчооноос боловсруулсан CPro 3.3 (Census and Survey Program) програм дээр боловсруулсан. Энэхүү програмаар мэдээлэл оруулах үеийн шалгалтуудыг дараахь байдлаар хийсэн.

1. Судалгааны асуулгад хариулагч сайн дураар хариулах ёстой боловч мэдээлэл оруулах явцад хариултыг оруулахгүй өнгөрөх явдлаас сэргийлэх үүднээс хариулт байх ёстой асуулт бүр дээр хариултыг заавал оруулахыг сануулахаар (хэрэв тухайн асуултад үнэхээр хариулаагүй байх тохиолдолд алгасахаар) програмыг боловсруулан мэдээллийг оруулсан.
2. Асуултын хариултад байхгүй кодуудыг оруулахад анхааруулах, оруулсан утга нь тодорхой хязгаарт багтахгүй байх тохиолдолд анхааруулахаар програмыг боловсруулан мэдээллийг оруулсан. Тухайлбал, төрийн албан хаагчдын насны хязгаарыг 18-65 гэж тодорхойлж өгсөн бөгөөд хэрэв 16 гэсэн утга оруулбал “Хязгаараас гадуурх утга оруулсан байна. Шалгана уу”
3. Асуулт хоорондын энгийн уялдаа холбоо, үсрэлт зэргийг оруулах програмын дагуу шалгасан.

Мэдээллийг оруулж дууссны дараа CPro 3.3 програмын Export Data хэрэгслийг ашиглан SPSS 13.0 (Statistical Package for the Social Sciences) програм руу хөрвүүлсэн. Мэдээллийн баазыг бэлтгэсний дараа мэдээллийн

баазаас энгийн давтамжийн хүснэгтүүдийг гаргаж мэдээллийг дахин шалгаж холбогдох засвар, өөрчлөлтийг хийсэн.

SPSS 13.0 програмыг ашиглан үр дүнгийн хүснэгтүүдийг гарган авсан. Энэ удаагийн судалгаа нь сайн дурын үндсэн дээр авсан санал асуулга байсан учраас хариулт өгсөн хариулагчдийн дүнгээр мэдээллийг боловсруулан гаргасан. Асуулгын бөглөлт 34-95 хувьтай байсан.

Төрийн албан хаагчдын судалгааны нэг асуулга нь нийтдээ 208, иргэдийн судалгааных 224, бизнес эрхлэгчдийн судалгааных 350 асуулттай байсан бөгөөд асуулт тус бүрээр хариулт авахаар програмыг боловсруулснаар нэг асуулгыг компьютерт шивж оруулахад дунджаар 10 минут зарцуулагдсан.

Бүлэг 2. СУДАЛГААНЫ ДҮН

2.1 Судалгааны ерөнхий дүн

Авлигын ерөнхий төлөв байдлын 2008 оны судалгаанд 21 аймаг, нийслэлийн 2990 иргэд, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид хамрагдлаа. Судалгаанд оролцогчдын 44.6 хувь буюу 1333 нь иргэд, 43.4 хувь буюу 43.4 хувь нь төрийн албан хаагчид, 12.0 хувь буюу 360 нь бизнес эрхлэгчид байлаа. Судалгаанд оролцогчдын 19.4 хувь нь Улаанбаатар хотоос, 18.5 хувь нь баруун бүсээс, 23.2 хувь нь хангайн бүсээс, 29.3 хувь нь төвийн бүсээс хамрагдсан байна. Нэг аймгаас дунджаар 115 хүн судалгаанд оролцжээ.

2.2 Иргэдийн судалгааны дүн

2.2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий үзүүлэлтүүд

Иргэдийн дүнд явуулсан Авлигын талаарх төсөөллийн судалгаанд 21 аймаг болон нийслэлийн, 16-82 насны, боловсролын түвшин, орлогын хувьд нийгмийн бүх давхаргыг төлөөлөхүйц 1333 иргэн хамрагдлаа.

Судалгаанд дунд эргэм насны хүмүүс голчлон оролцсон бөгөөд дундаж нас 36 байв. Тэдний 4.5 хувь нь 20 хүртэл насны, 34.6 хувь нь 21-36 насны, 28.7 хувь нь 31-40 насны, 24.4 хувь нь 41-50 насны, 7.8 хувь нь 51 болон түүнээс дээш насны иргэд байв. Судалгаанд оролцсон иргэдийн 56.2 хувь нь эмэгтэйчүүд, 43.8 хувь нь эрэгтэйчүүд байв.

Судалгаанд дээд болон түүнээс дээш боловсролтой иргэд голчлон оролцлоо. Өндөр боловсролтой иргэд авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааны талаар өөрийн гэсэн бодол, төсөөлөлтэй байдаг бөгөөд судалгаанд дээд болон түүнээс дээш боловсролтой иргэд оролцсон нь цуглуулагдсан мэдээллийн ач холбогдлыг нэмэгдүүлж байгаа юм. Судалгаанд оролцогчдын 50.6 хувь нь дээд, 20.5 хувь нь бүрэн дунд, 10.1 хувь нь тусгай буюу техник мэргэжлийн дунд, 9.9 хувь нь бүрэн бус дунд, 5.6 хувь нь магистр, доктор, 1.6 хувь нь бага боловсролтой иргэд байсан бол 1.7 хувь нь боловсролгүй иргэд байжээ.

Гэр бүлтэй, хүүхэдтэй буюу гэр бүлийн хувьд тогтворжсон, энэ хэмжээгээрээ нийгмийн амьдралд голчлон оролцдог иргэд энэ удаагийн судалгаанд голчлон оролцлоо. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 75.1 хувь нь гэр бүлтэй, 14.3 хувь нь ганцаараа амьдардаг, 10.6 хувь нь гэрлэж байгаагүй хүмүүс байв. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 77.7 хувь нь хүүхэдтэй хүмүүс байжээ. Судалгаанд оролцогчдын ам бүлийн дундаж тоо 4 байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 26.9 хувь нь 4 ам бүлтэй, 24.0 хувь нь 3 ам бүлтэй гэр бүл байжээ.

Судалгаанд оролцогчдын 49.1 хувь нь 300.0 мянга хүртэл, 30.8 хувь нь 300.0-500.0 мянга, 13.9 хувь нь 500.0 мянга болон түүнээс дээш төгрөгийн сарын дундаж орлоготой байгаа бөгөөд тэдний өрхийн сарын дундаж орлого 353.7 мянган төгрөг байна.

Газар зүйн байршлын хувьд судалгаанд 23.7 хувь нь нийслэл Улаанбаатар хотын, 58.3 хувь нь аймгийн төвийн, 20.1 хувь нь хөдөө орон нутгийн хүмүүс оролцлоо. Тэдний 83.7 хувь нь тухайн орон нутагтаа төрсөн цагаасаа болон 5 ба түүнээс дээш жилээр амьдарч байгаа бол 14.3 хувь 5 хүртэл жилийн дотор шилжин ирэгсэд байжээ.

2.2.2. Иргэдийн амьдралын түвшин

Судалгаанд оролцсон иргэдийн ихэнх нь амьдрал хүнд байна гэсэн дүгнэлтийг хийжээ. Судалгаанд оролцогчдын 45.0 хувь “Олсон орлогоо амьжиргаандаа дөнгөж хүргэж байна”, 15.7 хувь нь “Бүх зүйлээс татгалзаж, зөвхөн хоол хүнсэндээ зарцуулж байна”, 7.6 хувь нь “Заримдаа хоол хүнс хүрэлцэхгүй ядарч байна” гэж хариулсан бол 21.9 хувь нь “Хангалуун амьдарч байна, гэхдээ маш их хөдөлмөрлөж байна”, 5.4 хувь нь “Юугаар ч дутахгүй хангалуун амьдарч байна” гэж хариулжээ (Зураг 2.). Түүнчлэн судалгаанд оролцогчдын дийлэнх хэсэг нь буюу 72.3 хувь нь олсон орлогоо өдөр дутмын хэрэгцээндээ зарцуулдаг гэж хариулсан бол 14.5 хувь нь том том зарлага гаргахад зориулан хадгалдаг, 8.5 хувь нь зарим нэг хэсгийг нь томоохн зүйл авах, гадаадад амрах зорилгоор хадгалдаг, 4.7 хувь ирээдүйдээ зориулан хадгалдаг гэж хариулсан байна.

Судалгаанаас хоёр хүн бүрийн нэг нь ямар нэгэн сэтгэл зовоох зүйлтэй амьдарч байна гэж хариулжээ. “Сүүлийн үед өөрийн сэтгэл санааг Та ямар байна гэж дүгнэх вэ?” гэсэн асуултад 12.8 хувь нь сэтгэл санаа өөдрөг, өөртэй итгэлтэй байна, 34.5 хувь нь зарим нэг санаа зовох асуудалгүй байгаа ч ерөнхийдөө тайван байна гэсэн өөдрөг хариулт өгсөн бол 39.1 хувь нь зарим нэг юманд санаа зовж байна, 11.5 хувь нь сэтгэл зовж, айж байна гэж хариулжээ.

Иргэдийн талаас илүү хувь нь сүүлийн таван жилийн хугацаанд амьдралын түвшин дээшилсэн гэж үзэж байна. Судалгаанд оролцогчдын 56.6 хувь сүүлийн таван жилийн хугацаанд амьдралын түвшин дээшилсэн гэж хариулсан бол 20.6 хувь урьдын байсан түвшиндээ, 17.6 хувь нь доошилсон гэж үзжээ. Харин ихэнх найз нөхөдтэйгээ харьцуулахад 74.3 хувь нь дундаж түвшинд, 8.6 хувь нь дунджаас дээгүүр, 17.1 хувь нь дунджаас доогуур түвшинд байна гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 12.5 хувь өөрийн өнгөрсөн амьдралаа сайнаар дүгнэж байгаа бол, 59.0 хувь хэцүү үеүд байсан хэдий ч амжилттай даван туулсан, 25.1 хувь нь амжилтгүй, азгүй тохиолдлууд нь давамгалж байсан, 3.4 хувь азгүй тохиолдлоор дүүрэн байсан гэж дүгнэжээ.

Хангалттай мөнгөтэй бол эсвэл ойрын хугацаанд их хэмжээний орлого орж ирэх тохиолдолд иргэд олон зүйлийг худалдаж авна гэж хариулж байгаа хэдий ч орон сууц, хувийн байшин тэдний хамгийн эхний сонголт болж байна. Энэ байдал нийслэл Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд давамгайлж байна. Судалгаанд оролцогчдын 25.0 хувь нь орон сууц, 9.3 хувь нь гэрийн тавилга, 9.4 хувь нь автомашин, 9.2 хувь хувийн орон сууц худалдан авна гэж хариулжээ.

Иргэдийн талаас илүү хувь нь манай улс хөгжлийн зөв бодлоготой явж чадахгүй байна гэж дүгнэжээ. “Манай улс хөгжлийн зөв хандлагатай байна уу эсхүл бид буруу тийш “мухардалд” орж байна уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 50.6 хувь нь “мухардалд”-д орж байна, 16.5 хувь нь зөв хандлагатай байна гэж хариулсан бол 33.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Төрийн үүргийг судалгаанд оролцогчдын 22.7 хувь нь хууль сахиулах, тус бүр 15.8 хувь нь удирдах болон иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах, 14.9 хувь нь хянах, 11.2 хувь нь үйлчлэх, 8.8 хувь нь хамгаалах, 5.3 хувь нь туслах явдал юм гэж үзжээ.

Үнийн өсөлт (25.3%), ядуурал (17.6%), ажилгүйдэл (14.9%), төрийн албан тушаалтнуудын ашиг хонжоо хайсан байдал, авлига, хүнд суртал (10.3%), архидалт (8.2%) зэрэг нь манай нийгэмд учирч байгаа, иргэдийн сэтгэлийг хамгийн их зовоосон асуудлууд болж байна. Эндээс харахад бидний судалгааны гол зорилго болох авлига, хүнд суртал, төрийн албан тушаалтнуудын ашиг хонжоо хайсан байдал нь иргэдийн сэтгэлийг зовоож буй асуудлуудын нэг болж байна. Энд гарсан үр дүн нь АНУ-ын Азийн сангаас 2008 оны 9 дүгээр сард явуулсан судалгааны үр дүнтэй тохирч байгаа юм. Уг судалгаанд оролцогчдын 32.4 хувь нь үнийн өсөлт, 24.6 хувь нь ажилгүйдэл, 16.6 хувь нь ажилгүйдэл, 12.5 хувь нь авлигыг манай улсад тулгарч буй гол асуудлууд гэж хариулжээ.

2.2.3. Иргэдийн амьдрал дахь авлигын тохиолдлууд

Иргэдийн амьдралтай холбоотой төрийн үйлчилгээний 14 тохиолдлыг сонгон авч эдгээр тохиолдол бүрт авлига, хүнд сурталтай холбоотой асуудал тулгарч байсан эсэхийг тодруулсан юм. Авлига, хүнд сурталтай холбоотой асуудал хамгийн их тохиолдлуудад газар өмчлөх, газрын зөвшөөрөл авах (заримдаа, ихэнх тохиолдолд, байнга гэж хариулсан судалгаанд эзлэх хувь-54.9%); их, дээд сургуульд элсэн орох, суралцах (46.8%); эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж авах (45.9); хүүхдээ ерөнхий боловсролын чанартай сургуульд оруулах, амжилттай төгсгөх (45.8%); хэрэгтэй байгаа ажилд орох, албан тушаал дэвших (45.6%) зэрэг тохиолдлууд орж байна. Харин авлига, хүнд сурталтай холбоотой асуудал харьцангуй бага учирдаг тохиолдлуудад өндөр насны тэтгэвэр тогтоолгох (29.6%), цэрэг татлагын асуудлыг шийдэх (31.8), хүнд өвчнөө эмчлүүлэх эсвэл үнэ төлбөргүй хагалгаа хийлгэх (33.6%) зэрэг тохиолдлууд орж байна. Дээр дурдсан авлига, хүнд сурталтай холбоотой асуудал харьцангуй бага учирдаг тохиолдлуудын хувьд иргэдийн өдөр дутмын амьдралд байнга тохиолдоод байдаггүй тохиолдлууд байгаа юм. Гэтэл газар өмчлөх, газрын зөвшөөрөл авахыг үүнд оруулж болох хэдий ч иргэд энэ чиглэлийн үйлчилгээ авах бүртээ авлига хүнд сурталтай холбоотой асуудалтай учирч байсан болохыг харуулж байгаа юм.

“Та дээр дурдсан нөхцлүүдэд хээл хахууль өгсөн үү” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 57.2 хувь тийм, 42.8 хувь нь үгүй гэж хариулжээ. Хээл хахууль өгөөгүй шалтгаанаа 21.5 хувь нь үүнийг хийхэд дургүй хүрсэн

учраас, 21.3 хувь нь хээл хахуулийг хэрхэн өгдөгийг мэддэггүй, эвгүй байсан учраас, 20.0 хувь нь би хээл хахууль өгдөггүй зарчимтай учраас, 9.2 хувь нь хээл хахуулийн хэмжээ өндөр учраас өгөөгүй гэж тайлбарлажээ. Энд гарсан нэг нааштай үзүүлэлт нь хээл хахууль өгөхөөс татгалзсан иргэдийн 41.5 хувь нь авлигыг үзэн ядсанаас болон хээл хахууль өгөхгүй гэсэн зарчим дээр үндэслэн хээл хахууль өгөөгүй явдал юм.

Иргэдийн төсөөллөөр хээл хахууль өгөх санаачлага, шалтгаан нь ерөнхийдөө гурван эх үүсвэртэй бөгөөд судалгаанд оролцогчдын 30.3 хувь нь энэ тохиолдолд хээл хахуульгүйгээр асуудлаа шийдвэрлэх боломжгүй гэж урьдаас мэдэж байсан учраас, 24.0 хувь нь албан тушаалтан хээл хахууль өгөхийг шаардаагүй боловч би өгсөн нь найдвартай гэж шийдсэн учраас, 8.7 хувь нь албан тушаалтан надад санал болгосон, шаардсан эсвэл тийм байдалд оруулсан учраас хээл хахууль өгсөн гэж хариулжээ. Эндээс харахад авилга нь хэвшмэл үзэгдэл, тогтсон үнэ ханштай байдаг, нөгөө талаас иргэд өөрсдөө авлигыг бий болгодог гэж үзэж болохоор байна.

Төрийн үйлчилгээ авахдаа хээл хахууль өгч асуудлаа шийдвэрлэсэн иргэдийн хувьд төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн дундаж хэмжээ 520.9 мянган төгрөг байжээ (жигнэсэн дунджийн аргаа тооцож үзэхэд). Судалгаанд оролцсон, төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн 48.2 хувь нь 10.0-50.0 мянган төгрөгийн, 17.6 хувь нь 50.0-100.0 мянган төгрөгийн, 11.9 хувь нь 100.0-200.0 мянган төгрөгийн, 11.9 хувь нь 200.0-500.0 мянган төгрөгийн, 10.3 хувь нь 500.0 мянга болон түүнээс дээш төгрөгийн хахууль өгсөн гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчид дунджаар сарын дундаж орлогоосоо 47.3 хувиар илүү хэмжээний мөнгийг төрийн албан хаагчдад хээл хахууль хэлбэрээр өгсөн гэсэн дүн гарч байна. Төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн иргэдийн өгсөн хахуулийн хэмжээг орлогын түвшинтэй нь харьцуулан авч үзэхэд орлогын түвшин нь өгсөн авлигын хэмжээтэй хамаарах хамаарал дундаж түвшинд байна. Тухайлбал, 100.0 хүртэл төгрөгийн орлоготой иргэдийн дунд 500.0 мянган төгрөгөөс дээш төгрөгийн хээл хахууль өгсөн иргэдийн эзлэх хувь 8.0 хувь байгаа бол энэ үзүүлэлт нэг сая төгрөг болон түүнээс дээш орлоготой иргэдийн хувьд 16.0 хувь байна.

Судалгаанд оролцогчдын 12.1 хувь хахуулийн хэмжээ, “бэлэг”-ийн үнийг анхнаас мэдэж байсан, 27.0 хувь нь бараг тодорхой байсан, 24.0 хувь нь тийм ч тодорхойгүй байсан, 36.9 хувь нь тодорхойгүй байсан гэж хариулжээ.

Иргэдийн зүгээс төрийн албан хаагчдад хахууль өгснөөр төрийн албан хаагчдын асуудлыг шийдвэрлэх хурд, үр ашиг нэмэгдэж, иргэд өөрсөддөө ашигтай байдлаар асуудлаа шийдвэрлүүлж авч чаддаг байна. Ийнхүү хахууль өгснөөр албан тушаалтны үйл ажиллагаа (найрсаг байдал, асуудлыг шийдвэрлэх хурд, үр ашиг)-г 29.4 хувь нь мэдэгдэхүйц эрс өөрчлөгдсөн, 33.9 хувь нь зарим нэг талаараа өөрчлөгдсөн, 10.8 хувь ер өөрчлөгдөөгүй гэж үзсэн бол нөгөө талаас хахууль өгсөн иргэдийн хувьд 24.2 хувь нь асуудлыг шийдвэрлэх явц хурдассан, 14.0 хувь нь асуудлыг миний талд ашигтайгаар шийдвэрлэсэн, 12.8 хувь нь үүний үр дүнд тэд үүргийнхээ дагуу хийх зүйлээ хийхэд хүргэсэн, 10.6 хувь нь зарим нэг хэцүү

зүйлээс зайлсхийх боломж олгосон гэж үзсэн бол 9.7 хувь хахууль өгснөөр ямар ч үр дүнд хүрээгүй гэж үзжээ.

Хахууль өгсөн ихэнх хүмүүсийн хувьд авлигад автсан төрийн албан хаагчдыг, төрийн эрх мэдлийг үзэн ядах зэрэг эвгүй сэтгэгдэл төрдөг байна. Хахууль өгч, асуудлаа шийдвэрлүүлсэн иргэдийн 74.4 хувьд нь тухайн үед дээрх байдлаар эвгүй сэтгэгдэл төрсөн гэж хариулсан бол 2.5 хувь нь асуудлаа шийдвэрлүүлсэндээ сэтгэл хангалуун байсан, 2.3 хувь нь ямар нэг сэтгэгдэл төрөөгүй, хэвийн үзэгдэл мэтээр хүлээн авсан гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь 57.5 хувь нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ асуудлыг шийдвэрлэхийн тулд албан тушаалтанд хахууль өгч байсан гэж хариулжээ. Хугацааны давтамжийн хувьд судалгаанд оролцогчдын 31.0 хувь нь нэг жилийн өмнө, 26.4 хувь нь хагас жилээс нэг жилийн дотор, 20.7 хувь нь нэг сараас хагас жилийн дотор, 11.6 хувь нь долоо хоногоос нэг сарын дотор, 10.3 хувь нь долоо хоногийн өмнө энэ явдал тохиолдсон гэж хариулжээ (Зураг 4.). Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдад хахууль өгсөн хугацааны давтамж нь дунджаар 210 хоног буюу 7 сар байна.

Судалгаанд оролцогчдын 8.3 хувь нь долоо хоногийн дотор хамаатан садан, найз нөхөд, хамт ажиллагчдаас хахууль өгсөн талаар сонссон, 13.0 хувь нь нэг долоо хоногоос сарын дотор, 13.4 хувь нэг сараас хагас жилийн дотор, 7.3 хувь нь жилийн дотор энэ талаар сонссон гэж хариулжээ. Тэгэхээр эргэн тойрны хүмүүсээсээ хахууль өгсөн талаарх мэдээллийг сонссон байх дундаж хугацаа нь 114 хоног буюу 3 сар 24 хоног байна.

Боловсролын салбар. Иргэдийн дунд их, дээд сургуульд элсэн ороход авлигатай холбоотой асуудал ихээхэн тулгардаг гэж үздэг. Судалгаанд оролцогчдын 13.2 хувь нь өөрөө болон хүүхдээ сүүлийн 10 жилийн хугацаанд их дээд сургуульд элсэн ороход шалгалтаа амжилттай өгөхөд дээд сургуулийн багш, албан хаагчдад мөнгө, эд зүйл өгч байсан гэж хариулжээ.

Эрүүл мэндийн үйлчилгээ. Харьяаллын эмнэлэгт нь ямар нэг үйлчилгээ дутмаг байх эсхүл муу, чанаргүй байвал иргэдийн 27.5 хувь төлбөртэй эмнэлэгээр үйлчлүүлдэг, 20.0 хувь нь тухайн нөхцөл байдалд тохируулан үйлчилгээ авдаг, 18.6 хувь нь эмнэлгийн ажилтнуудад төлбөр төлж шаардлагатай эмчилгээ, үйлчилгээгээ авдаг, 12.0 хувь нь эмнэлгийн тусламжаас татгалзаж өөрөө өөрийгөө эмчилдэг гэж хариулжээ. Зөвхөн 8.3 хувь нь манай эмнэлгийн бүх юм нь сайн, иймэрхүү асуудал байдаггүй гэж хариулжээ.

Сүүлийн жилийн хугацаанд иргэдийн 16.0 хувь нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байхдаа оношлогоо, шинжилгээ өгөхөд, 15.8 хувь нь эмнэлэгт оношлогоо, шинжилгээ өгөхөд, 11.3 хувь нь чанартай болон цаг үеэ олсон хагалгаа хийлгэх болон эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байх үед, 8.8 хувь нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байхад хэвийн /хоол, өрөө тасалгаа, шаардлагатай эмчилгээ/ үйлчилгээ авахад, 7.9 хувь нь яаралтай эмнэлгийн тусламжийн үед, 6.5 хувь нь гэртээ эмнэлгийн тусламж авахад эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад албан бус төлбөр буюу бэлэг сэлт, авлига өгсөн байна. Харин 23.2 хувьд нь ийм асуудал тулгараагүй байна.

Шүүх үйл ажиллагаа. Сүүлийн хоёр жилийн хугацаанд судалгаанд оролцогчдын 37.2 хувь нь эрх нь зөрчигдсний улмаас шүүхэд хандмаар санагдсан ч хандаагүй гэж хариулжээ.

Төрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл багатай, уг мэдээлэл нь нээлттэй бус байдгаас иргэд зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар хаана, хэнд хандахаа мэдэхгүй хохирдог байна. Судалгаанд оролцогчдын 33.0 хувь нь төрийн үйлчилгээний талаар сайн мэднэ, 32.6 хувь нь дунд зэрэг, 26.1 хувь нь тааруухан, 8.4 хувь нь огт мэдэхгүй гэж хариулжээ. Төрийн байгууллагуудын үзүүлж буй ажил үйлчилгээнд иргэдийн 73.9 хувь нь сэтгэл хангалуун бус, 26.1 хувь сэтгэл хангалуун байдаг байна.

Судалгаанд оролцогчдын 34.4 хувь нь албан тушаалтнуудын асуудлыг шийдвэрлэсэн талаар сэтгэл хангалуун бус байгаагаа хаана, хэнд хандахаа мэдээгүй гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын 15.4 хувь нь албан тушаалтны буруу үйл ажиллагааны талаар сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэгэн байгууллагад хандсан гэж хариулсан бөгөөд тэдний 63.0 хувийнх нь асуудлыг шийдвэрлэж өгөөгүй бол 21.1 хувийнх асуудлыг зардал, чирэгдэл болсны эцэст шийдвэрлэсэн, 15.9 хувийнх асуудлыг хууль журмын дагуу шуурхай шийдэж өгсөн байна (Зураг 5.).

Иргэдийн 61.0 хувь нь авлига авах сэдэлттэйгээр хүнд суртал гаргаж чирэгдүүлэх, 75.4 хувь нь арын хаалга /танил тал/-гүй бол ажил бүтэхгүй байх, 52.0 хувь нь албан хаагчдын зүгээс хууль, дүрэм зөрчих, зохисгүй шаардлага, хүсэлт тавих, 58.8 хувь нь албан тушаалаа хэтрүүлэн ашиглах, 65.6 хувь нь ажлаа мэдэхгүй байх, 62.9 хувь нь ялгаварлан гадуурхах байдал, 75.0 хувь нь танил талаа харж асуудлыг шийдвэрлэх зэрэг байдалтай төрийн байгууллагуудаар үйлчлүүлж байхдаа нэг болон түүнээс олон удаа тулгарч байжээ.

2.2.4. Иргэдийн итгэл үнэмшил

Италийн нийгмийн зүтгэлтэн Н.Макиавелли нэгэнтээ “Авлига нь ямар ч олон хэлбэр, төрхтэй байлаа ч эцсийн дүндээ түүний мөн чанар нь нийгмийн улс төрийн амьдралын шинж чанар, динамик байдлыг тодорхойлох бөгөөд **хүний өөрийн мөн чанартай** байнгын холбоотой” гэж хэлсэн байдаг. Түүний хэлсэнчлэн авлига өгөхгүй, авахгүй байх, нэхсэн тохиолдолд илчлэх эсэх нь тухайн хүний өөрийн мөн чанартай холбоотой юм.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 73.5 хувь нь хүмүүстэй харьцахдаа анхааралтай хандах хэрэгтэй гэж үзэж байгаа бол ердөө 13.7 хувь нь хүмүүст итгэж болно гэж үзжээ. Засгийн газар, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг 23 төрлийн нийгмийн институциудад итгэх итгэлийг асуух замаар иргэдийн тухайн институцид болон нийгэмд хандах хандлагыг тодорхойлсон юм.

Дээр дурьдсан 23 төрлийн институциудаас боловсролын байгууллагууд (бүрэн итгэдэг болон итгэдэг гэж хариулсан хүмүүсийн эзлэх хувь-62.1%), батлан хамгаалах зэвсэгт хүчин (62.0%) институци иргэдийн итгэлийг хүлээсэн институциэр шалгарч байгаа бол газрын алба (26.2%), гаалийн байгууллага (25.9), улс төрийн намууд (17.4%) иргэдийн итгэлийг хамгийн бага хүлээдэг байгууллагууд болж байна.

Судалгаанд оролцогчдоос өнөөгийн нийгмийн байдлын талаар зарим нэг асуултуудыг асууж хариулт авсан юм. “Засгийн газрын үүрэг бол хүн болгоныг ажилтай болгох” гэдэгтэй судалгаанд оролцогчдын 58.6 хувь нь бүрэн болон санал нийлж байна гэж хариулсан бол 33.7 хувь нь санал нийлэхгүй, санал огт нийлэхгүй байна гэж хариулжээ. Иргэдийн гуравны нэг нь ажил эрхэлж амьдралаа залгуулан авч явах тухайн хүний өөрийнх нь үүрэг гэж үзэж байна.

“Би сонгууль өгч байхдаа хэний төлөө санал өгч байгаагаа мэддэггүй” гэдэгтэй судалгаанд оролцогчдын 27.1 хувь нь санал нийлж байна гэж хариулсан хэдий ч “Ардчилал өрнөснөөр бид өнөөдөр хамгийн шилдэг хүмүүсээ сонгож чадаж байна” гэдэгтэй зөвхөн 23.6 хувь нь л санал нийлж байна гэж хариулжээ. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 77.1 хувь нь “Бид нарын сонгосон гишүүд маш хурдан бидний хүсэн хүлээж буй зүйлийг мартдаг” гэдэгтэй санал нийлж байна гэж хариулжээ. Эндээс харахад иргэд маань сонгуульд саналаа өгөхдөө нэр дэвшигчийн талаарх өнгөцхөн мэдээлэлд үндэслэн санал өгдөг эсвэл нэр дэвшигчдийн амлалт, мөрийн хөтөлбөрт хууртаж сонголтоо хийдэг, сонгуулийн дараа хамгийн сайн хүнийг сонгож чадаагүй болохоо мэддэг, сонгогдсон гишүүд нь иргэд сонгогчидоо маш хурдан мартдаг гэж дүгнэж болох юм.

“Юу ч ярьж байсан мөнгө бол бүхнийг шийднэ” гэдэгтэй судалгаанд оролцогчдын 55.6 хувь нь санал нийлж байна гэж хариулсан бол “Өнөөдөр хэн ч хуулийг мөрдөхгүй байна. Иймд хууль мөрдөх нь тэнэг ба гэнэн зүйл юм” гэдэгтэй 48.8 хувь нь санал нийлж байна гэжээ. Иргэдийн тэн хагас нь хууль мөнгөтэй хүнд үйлчилж байна, иймд хуулийг мөрдөх шаардлагагүй гэж үзэх болсон нь анхааралдаа авах шаардлагатай мэдээлэл юм.

Түүнчлэн том бизнес эрхлэгчид, банкныхан улс төр, хууль хяналтын хүрээнд нөлөөтэй болж, хууль тэдэнд үйлчилж байна гэж иргэдийн ихэнх нь үзэж байна. “Том бизнес эрхлэгчид, банкныхан эрх мэдэл, нөлөө ихтэй болж байна” гэдэгтэй судалгаанд оролцогчдын 73.8 хувь нь санал нийлж байна, 19.3 хувь нь санал нийлэхгүй байна гэж үзсэн бол 6.9 хувь хариулж мэдэхгүй байна гэжээ.

Үг хэлэх эрх чөлөө нь дур зоргоороо авирлахад хүргэж байна гэдэг дээр иргэдийн санал хуваагдаж байна. Судалгаанд оролцогчдын 51.8 хувь санал нийлж байна, 39.9 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан бол 8.4 хувь хариулж мэдэхгүй байна гэжээ. Үг хэлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө гэсэн асуудлууд ардчилсан нийгмийн үед урган гардаг хэдий ч нөгөө талаар хариуцлагатай сэтгүүл зүй, хүнийг эрхийг хүндэтгэх зэрэг асуудлууд эсрэгээр нь гарч ирдэг юм.

Манай улсад 1990-ээд оны эхээр ялсан ардчилсан хувьсгалын үр дүнд бид бүхэн нийгмийн хувьд хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг, эдийн засгийн хувьд зах зээлийг эдийн засгийг цогцлоон бий болгохоор зорьж ирсэн билээ. Зах зээлийн эдийн засгийн үед зөвхөн ашгийн төлөө ажиллах ёстой гэсэн үзэл баримтлал байдаг. Судалгаанд оролцогчдын хувьд “Бид өнөөдөр капиталист нийгэмд амьдарч байгаа юм чинь хүн хүндээ чоно, хүчтэй нь дийлдэг гэсэн капитализмын хуулиар амьдрах ёстой” гэдэгтэй

судалгаанд оролцогчдын зөвхөн 22.4 хувь нь л санал нийлж байгаагаа илэрхийлжээ.

“Авлигын эсрэг” Монгол Улсын хуулийн “Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрх” гэсэн 18 дугаар зүйлийн 18.1.7-д “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” гэж заасанчлан Авлигатай тэмцэх газрын ойрын үеийн зорилтуудын нэг нь төрийн байгууллагуудын шударга байдлын түвшинг тодорхойлох явдал юм. Иргэдээс авсан энэ удаагийн судалгаанд Засгийн газар, УИХ-ын гишүүд, төрийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг 29 төрлийн институцуудын шударга байдлыг иргэдээр үнэлүүлсэн юм.

Тухайн институцийг маш шударга, шударга, харьцангуй шударга гэж хариулсан иргэдийн эзлэх хувийн жингээр эрэмбэлүүлэн авч үзэхэд шударга байдлын үзүүлэлтээр ерөнхий боловсролын сургуулиуд (76.1%), банкны байгууллага (68.3%) зэрэг байгууллага, хүмүүс тэргүүлж байгаа бол газрын алба (46.7%), УИХ-ын гишүүд (43.9%), улс төрийн намууд (37.0%) сүүлийн байрыг эзэлжээ.

2.2.5. Авлигын тодорхойлолт, цар хүрээ, хэлбэр шалтгааны талаарх иргэдийн төсөөлөл

“Авлигын эсрэг” Монгол Улсын хуулинд авлигыг “...хуулийн үйлчлэлд хамаарах этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг” ойлгоно гэж тодорхойлсон байдаг. Энэ удаагийн судалгаагаар бид бүхэн иргэд авлигыг хэрхэн тодорхойлж байна вэ гэдгийг тодруулах зорилго бүхий асуултыг оруулсан юм. Иргэд авлигыг хэрхэн ойлгож байна вэ гэдгийг тодорхойлох нь уг үзэгдлийг судлахад чухал ач холбогдолтой юм. Иргэдийн зүгээс харьцангуй олон санал авсан тодорхойлолтууд нь “Төрийн албан тушаалын эрх мэдлээр бизнес хийх” (14.2%), “Улс төрч, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчид нэгдэн нэг бүлэг болж иргэд улс орныхоо төлөө бус зөвхөн өөрсдийн төлөө үйл ажиллагаа явуулах” (12.2%), “Өөрсөддөө ашигтай шийдвэр гаргуулахын тулд том бизнес эрхлэгчид төрийн өндөр албан тушаалтнуудыг өөрийн талд оруулах” (10.3%), “Төрийн албан хаагч ах дүү, хамаатан садан, найз нөхөддөө давуу байдал олгох” (10.2%) зэрэг байлаа.

Хүнээр ажил хөөцөлдүүлж байгаа юм чинь зохих шагнал, урамшууллыг нь өгөх хэрэгтэй гэдэгтэй судалгаанд оролцогчдын 55.0 хувь санал нийлж байна гэжээ. Харин шагнал, бэлэг өгсөн тохиолдолд илүү үйлчилгээ хүртэх боломжтой, өнөө үед хахуульгүйгээр ямарваа ажил бүтээх боломжгүй гэдэгтэй 47.9-50.4 хувь нь санал нийлж байгаагаа илэрхийлжээ. Чихрийн цуглуулга, архи зэрэг болон хоолонд урих нь авлигад тооцогдохгүй гэж судалгаанд оролцогчдын 39.8 хувь нь үзжээ.

Иргэдийн 87.7 хувь нь манай улсад төрийн албан хаагчдын дунд авлига, хээл хахууль газар авсан гэж үзэж байна. Судалгаанд оролцогчдын 59.8 хувь нь албан тушаалтнуудын ихэнх хувь нь авлигад автсан, 27.9 хувь

нь бага хувь нь авлигад автсан, 10.6 хариулж мэдэхгүй байна гэж хариулсан бол ердөө 1.7 хувь нь албан тушаалтнууд огт авлигад автаагүй гэж хариулжээ (Зураг 6.). 2008 оны 9 дүгээр АНУ-ын Азийн сангаас явуулсан Монголын авлигын суурь судалгаагаар манай улсад авлига нийтлэг үзэгдэл гэж үзсэн иргэдийн эзлэх хувь 83.0 хувь байсан байна.

Нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтнуудын буюу аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо, багийн засаг дарга, засаг даргын тамгын газрын албан хаагчид авлигад автсан эсэх талаар асуухад 37.3 хувь нь эдгээр байгууллагын албан хаагчдын ихэнх нь авлигад автсан, 17.1 хувь нь бага хувь нь авлигад автсан, 13.2 хувь нь бүх шатны албан хаагчид авлигад автсан, 4.1 хувь эдгээр байгууллагын албан хаагчид авлигад автаагүй гэж хариулсан бол 28.3 хувь нь хариулж мэдэхгүй байна гэжээ.

Төрийн дээд удирдлагууд ашиг хонжоо хайж, зөвхөн өөрсдөө баяжихын тулд төрийн албан тушаалд очдог гэсэн яриа байдаг. Үүнтэй санал нийлж байгаа эсэхийг судалгаанд оролцогчдоос тодруулсан юм. Судалгаанд оролцогчдын 81.4 хувь санал нийлж байгаагаа, 7.9 хувь санал нийлэхгүй байгаагаа илэрхийлсэн бол 10.7 хувь хариулж чадахгүй байна гэжээ.

Иргэд өөрсдөө асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд авлигыг төрийн албан хаагчдад санал болгож, өгдөг, өөрөөр хэлбэл, авлига үүсэх эх сурвалж нь иргэд өөрсдөө байдаг гэсэн үзэл баримтлалыг нотлох асуултыг санал асуулгад оруулж өгсөн юм. Судалгаанд оролцогчдын 11.5 хувь үүнтэй санал нийлэхгүй байгаагаа шууд илэрхийлсэн бол 17.9 хувь нь энэ нь манай амьдралын салшгүй хэсэг, үүнийг хийхгүйгээр юу ч шийдвэрлэж чадахгүй, 23.8 хувь нь үүнээс зайлсхийж болно, тэгэхдээ хахууль өгөх нь асуудлыг хялбар шийдэхэд нөлөөлдөг, 35.9 хувь нь үүнээс татгалзах хэрэгтэй, учир нь авлига манай төр засаг, бидний амьдралыг сүйтгэж байна гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын 48.2 хувь нь албан тушаалтнууд авлига өгөх гарцаагүй байдлыг бий болгодог, санал болгодог шаарддаг гэж үзсэн бол 22.5 хувь нь бусад хүмүүс авлига өгсөн нь дээр гэж ятгадаг, иргэд өөрсдийн санаачлагаар өгдөг, 18.4 хувь нь тухайн асуудлыг шийдвэрлэхэд авлига өгөх нь гарцаагүй, өөр арга зам байхгүй гэдэг үүднээс авлига өгдөг гэж үзжээ. Тэгэхээр авлига өгөх санаачлага нь гурван эх үүсвэртэй гэж үзэж болох юм.

Төрийн байгууллагууд, бусад институцийн хувьд авлигад хэр автсныг судалгаанд оролцогчдоор тодорхойлуулан авлигад харьцангуй их автсан, нэлээд автсан гэж үзсэн иргэдийн дүнгээр авч үзэхэд эхний таван байранд УИХ-ын гишүүд (68.7%), газрын алба (64.2%), гаалийн байгууллага (59.7%), улс төрийн намууд (57.0%), эмнэлэгүүд (56.3%) оржээ. Авлигад харьцангуй автаагүй институцээр банкны байгууллага (30.5%) олон нийтийн байгууллагууд (25.8%) орж байна.

Сүүлийн гурван жилийн хугацаанд тухайн аймаг, нийслэл, дүүрэгт авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн талаарх асуултад иргэдийн 41.3 хувь нь өссөн, 20.3 хувь нь өөрчлөгдөөгүй гэж үзсэн бол ердөө 5.8 хувь нь буурсан гэж хариулжээ. Авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн талаар иргэдийн гуравны нэг нь ямар нэг төсөөлөлгүй байна. Дараагийн гурван жилд хэрхэн өөрчлөгдөх талаарх иргэдийн үзэл бодлыг өмнөх гурван

жилийн талаарх төсөөлөлтэй харьцуулахад өснө гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 9.2 пунктээр өссөн гэж үзсэн иргэдийн эзлэх хувиас илүү байна. Иргэдийн 32.1 хувь нь өснө, 21.3 хувь нь өөрчлөгдөхгүй гэж үзсэн бол 12.3 хувь нь буурна гэж үзжээ.

Иргэдийн дунд авлигын шалтгааны талаарх олон төрлийн үзэл байдаг хэдий ч авлига төрийн үйл ажиллагааны доголдлоос болж бий болдог гэсэн үзэл илүү давамгайлж байна. Судалгаанд оролцогчдын 43.6 хувь нь авлига төрийн үйл ажиллагааны доголдлоос болж бий болдог, 19.2 хувь нь улс төрийн буруу тогтолцооны улмаас бий болдог, 18.4 хувь нь авлигын шалтгаан нөхцөл нь бидний зах зээлд шилжих явцад бий болсон, 8.7 хувь нь авлигын шалтгаан нөхцөл нь манай түүх, уламжлалт харилцаанд байгаа гэж хариулжээ.

Энэ удаагийн судалгаагаар авлига үүсгэх шалтгаан нөхцөл болж болох 26 асуудлыг тавьж эдгээр нь авлига үүсэх чухал нөлөөтэй эсэхийг тодруулсан юм. Эдгээр асуудлыг чухал гэж үзсэн хүмүүсийн эзлэх хувиар нь эрэмбэлж үзвэл төрийн хяналтын систем сул (63.4%), хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны сул дорой байдал (60.1%), улс төрчид болон төрийн албан тушаалтнуудын ёс зүйгүй байдал (59.0%) зэрэг шалтгаан нөхцлүүд тэргүүлж байгаа бол нөгөө талаар албан тушаалтнуудын үйл ажиллагаа заавар, журмаар муу зохицуулагдсан (41.5%), дэндүү их заавар, дүрэм, журам байдаг (33.4%), түүхэн талаас нь авч үзвэл авлига нь Монголчуудын амьдралын хэв шинжийн нэг хэсэг болж ирсэн (31.7%) зэрэг шалтгаан нөхцлүүд жагсаалтын сүүлийн байруудыг эзэлжээ (Шалтгаан нөхцөл тус бүрээр хариултыг хавсралт хүснэгтээс үзнэ үү). Эндээс дүгнэж үзэхэд төрийн хяналтыг сайжруулах, улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх нь авлига үүсэхээс урьдчилан сэргийлэх арга зам юм гэж үзэж болохоор байна.

Шүүхийн тогтолцоо, шүүгчдийн үйл ажиллагааны талаар олон янзын яриа байдаг. Шүүхийн тогтолцоо, шүүгчдийн үйл ажиллагааны талаарх зарим асуудлуудад иргэд хэрхэн хандаж байгааг энэ удаагийн судалгаагаар тодруулсан юм. Шүүхэд хэн их төлсөн нь ялдаг, түүнчлэн шүүхэд асуудлыг танил тал, найз нөхдийн шугамаар шийдвэрлэдэг гэдэгтэй иргэдийн харгалзан 72.4 болон 75.0 хувь нь ямар нэг байдлаар санал нийлж байна гэж хариулжээ. Түүнчлэн ихэнх тохиолдолд ямар нэгэн удирдах албан тушаалтан шүүгчийн гаргах шийдвэрт нөлөөлдөг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 68.6 хувь нь санал нийлж байна гэжээ.

Шүүхэд хандаад шударга ёсыг олохгүй, мөн албан бус зардал нь дэндүү их учир ихэнх иргэд шүүхэд хандах дургүй, шүүгчдийн мэдлэг, ур чадвар муу тул асуудлыг шийдэж чаддаггүй гэдэгтэй судалгаанд оролцогчдын 57.9-67.1 хувь нь санал нийлж байна гэж хариулсан байна. Нөгөө талаар өнөөдөр иргэд шүүхэд эрхээ хамгаалуулан асуудлаа хуулийн дагуу, шударгаар шийдүүлэх боломжтой болсон гэдэгтэй иргэдийн 48.9 хувь нь санал байгаагаа илэрхийлжээ.

Шүүх хараат бус, бие дааж үйл ажиллагаагаа явуулж чаддаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 44.0 хувь санал нийлж байна гэсэн бол 36.7 хувь нь санал нийлэхгүй байна, 19.3 хувь нь хариулж мэдэхгүй байна гэжээ.

Түүнчлэн шүүгчийн цалин бага иймд тэд авлига авч эхэлсэн гэдэгтэй судалгаанд оролцогчдын 56.7 хувь санал нийлж байна гэж хариулжээ.

Хээл хахууль авсан албан тушаалтан шүүх хурал дээр өөрийгөө хэрхэн зөвтгөж болох вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 25.2 хувь нь “Баригдаж мэдэгдсэн нь л би болохоос бүгд авч байгаа шүү дээ”, 21.2 хувь нь “Манай цалин бага, би гэр бүлээ тэжээх хэрэгтэй байна шүү дээ”, 13.0 хувь нь “Манай удирдлага аваад байхад би яагаад авч болохгүй гэж”, 9.8 хувь нь “Би өөрийн хүсэлтээр хахууль аваагүй, дарга нарын шахалтаар л хийсэн шүү дээ”, тус бүр 7.8 хувь нь “Би их удаан ажиллаж байгаа, мэргэшсэн, гэтэл намайг одоо болтол дэвшүүлэхгүй байна” болон “Надад маргааш юу болохыг мэдэхгүй. Би ирээдүйн талаар бодох хэрэгтэй” гэж хэлж болох юм гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын 52.5 хувь нь даргаа авлигатай холбоотой талаар сонсоод мэдээлэл бичиж өгсөн хүнийг үнэнч шударга хүн гэж тодорхойлно гэж хариулсан бол 4.3 хувь нь баатар гэж үзэж, 28.6 хувь нь мангар, өшөө авагч, атаархагч, урвагч гэж тодорхойлжээ.

Судалгаанд оролцогчдын 27.5 хувь нь 2005 оноос хойш авлига хамгийн их тархсан, 18.4 хувь нь 1997-2005 оны хооронд, 12.7 хувь нь 1990-1997 оны хооронд, 11.2 хувь нь социализмын үед, 6.9 хувь нь ардын хувьсгалаас өмнө хамгийн их тархсан гэж үзжээ (Зураг 9).

2.2.6. Авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх иргэдийн бодол, энэхүү үйл ажиллагаанд хандах хандлага

Төрийн дээд удирдлагуудын зүгээс ямар үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлбэл тэд авлигатай тэмцэх чиглэлээр бодитой ажил хийж эхэлж байна гэж үзэх вэ гэсэн асуултад хамгийн их хувь нь буюу 28.6 хувь нь хахууль авсан, өгсөн талуудад ногдуулах эрүүгийн хариуцлагыг чангаруулах гэж хариулсан бол дараа нь 11.7 хувь төрийн дээд удирдлагын дунд авлигатай тууштай тэмцэх, 9.8 хувь төрийн дээд удирдлагууд өөрсдөө шударга үнэнч байх жишээ болох гэж хариулсан нь оржээ.

Манай улсын авлигыг үгүй болгох стратегийг боловсруулах боломж олдвол дараах зүйлүүдээс алийг нь авч хэрэгжүүлэх вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 34.4 хувь нь авлигыг бий болгож буй нөхцлүүдийг эрхзүйн, эдийн засгийн гэх мэт хүрээнд үгүй болгох хэрэгтэй, 28.1 хувь нь шударга бус удирдагчдыг шударга удирдагчдаар солих, 13.5 хувь нь авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагааг эрчимтэй, тогтмол хийх хэрэгтэй, 13.0 хувь нь авлигач нарыг шийтгэж байх шаардлагатай гэж хариулсан бол 2.9 хувь нь ямар ч стратеги шаардлагагүй, авлигатай тэмцэх нь үр дүн байхгүй гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь (54.8%) нь авлигатай бид бүгдээрээ тэмцэж байж үгүй болгож чадна, 14.4 хувь нь авлигыг хэрэв улс төрчид хүсвэл үгүй болгож чадна гэж үзсэн бол 18.4 хувь нь авлига урьд нь байсан, цаашдаа ч байх болно гэсэн үзэл бодолтой байгаагаа илэрхийлжээ.

Зарим орнуудад авлигын талаарх нэргүй мэдээлэл авах явдал их байдаг. Энэхүү системийг манай улсад нэвтрүүлэх тал дээр иргэдийг үзэл бодлыг тодруулахад 40.1 хувь нь энэхүү системийг нэвтрүүлэх хэрэгтэй гэж

үзсэн бол 47.1 хувь нь мэдээллийн нууцлалыг хадгалах, нэргүй мэдээллээр гэмгүй хүнийг хэлмэгдүүлэх, нэргүй мэдээллийг хэрхэн шалгах нь тодорхой бус зэрэг шалтгааны улмаас энэхүү систем нь үр ашиггүй гэж үзжээ.

Гадаадын зарим орнуудад авлига, хээл хахууль байдаггүйн учир шалтгааныг судалгаанд оролцогчдын 22.0 хувь нь төрийн албан албан хаагчдын цалин хангамж өндөр, амьдралын баталгаа сайн байдагтай, 15.9 хувь нь тэндхийн цагдаа авлига авдаггүй, хууль тогтоомж нь тогтсон, хүчтэй байдаг, тэнд авлигачдыг барьж шийтгэдэгтэй, 6.2 хувь нь эдгээр орнуудын түүх уламжлал нь авлига хээл хахуулийг хүлээн зөвшөөрдөггүйтэй, 6.0 хувь нь эдгээр орнуудад иргэд, бизнес эрхлэгчид нь албан тушаалтнуудаас хамаардаггүй, тэд ямар нэгэн зөвшөөрөл худалдан авах шаардлага байхгүйтэй холбон авч үзсэн бол 5.9 хувь нь авлига хаана ч байдаг гэж үзжээ.

Авлигын талаарх мэдээлэлд иргэдийн талаас илүү хувь нь идэвхтэй ханддаг байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 8.7 хувь нь өөрөө хайж олж мэддэг, 47.4 хувь нь тааралдахаар нь уншдаг, үздэг, сонсдог гэсэн бол 17.7 хувь нь надад сонин биш, мэдээлэлд итгэдэггүй учир сонирхдоггүй гэж хариулжээ.

Авлигын талаарх мэдээллийг сонирхдог хүмүүсийн хувьд энэ талаарх мэдээллийг олж авдаг гол суваг нь телевиз болон сонин байдаг байна. Судалгаанд оролцогчдын 33.4 хувь нь телевизээс, 29.1 хувь нь сонингоос, 15.2 хувь найз нөхөд, хамт ажилладаг хүмүүсээсээ энэ чиглэлийн мэдээллийг олж авдаг гэж хариулжээ.

Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлэгийг хянан шилгах чиг үүрэг бүхий хараат бус бие даасан, төрийн тусгай байгууллага бөгөөд байгуулагдснаас хойш 2 жил гаран болж байна. Энэ хугацаанд хуульд заасан үүргээ хэрэгжүүлэн ажиллаж ирсэн. Авлигатай тэмцэх газрын талаарх иргэдийн бодлыг тодорхойлох зорилго бүхий хаалттай хариулт бүхий асуултыг судалгаанд оруулсан. Судалгаанд оролцогчдын 44.7 хувь нь АТГ бол ард түмний байгууллага, 29.5 хувь нь хууль хяналтын байгууллага, 13.4 хувь нь төрийн байгууллага, 6.6 хувь нь Засгийн газрын байгууллага, 5.8 хувь нь УИХ-ын байгууллага гэж тодорхойлжээ.

2.3 Бизнес эрхлэгчдийн судалгааны дүн

2.3.1 Бизнес эрхлэгчдийн ерөнхий үзүүлэлтүүд

Бизнес эрхлэгчдийн судалгаанд нийт 21 аймаг болон нийслэлийн, эдийн засгийн үйл ажиллагааны салбар болон үйл ажиллагааны хэмжээ, цар хүрээгээрээ нийт эх олонлогийг төлөөлж чадахуйц бизнесийн нэгжүүдийг төлөөлсөн 345 бизнес эрхлэгчид хамрагдлаа. Тухайлбал, эдийн үйл ажиллагааны чиглэлийн хувьд судалгаанд хамрагдсан нэгжүүдийн 32.5 хувь нь жижиглэнгийн болон бөөний худалдааны, 20.7 хувь нь үйлчилгээний, 8.9 хувь нь барилга угсралт, засвар үйлчилгээний, 6.1 хувь нь хөнгөн үйлдвэрлэлийн, 5.4 хувь нь хөдөө аж ахуйн, 26.4 хувь нь банк санхүү, тээвэр, мэдээллийн технологи болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нэгжүүд байжээ.

Судалгаанд хамрагдсан нэгжүүдийн 57.2 хувь нь 9 хүртэл ажиллагчидтай, 36.6 хувь нь 10-100 хүртэл ажиллагчидтай, 6.2 хувь нь 101 болон түүнээс дээш ажиллагчидтай нэгжүүд байв.

“Улсын хэмжээнд танай бизнесийн үндсэн үйлдвэрлэл /үйлчилгээ/ тухайн зах зээлийнхээ хэдэн хувийг эзэлдэг вэ” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 58.2 хувь нь 5 хувиас бага, 21.1 хувь нь 5-20 хувь, 12.5 хувь нь 21-50 хувь, 8.2 хувь нь 50 ба түүнээс дээш хувийг эзэлдэг гэж хариулжээ.

Нийт бизнес эрхлэгчдийн 81.0 хувь нь тухайн орон нутгийнхаа зах зээлд бүтээгдэхүүн үйлчилгээгээ борлуулдаг бол 15.3 хувь нь Монгол Улсын зах зээлд, 3.6 хувь олон улсын зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулдаг байна.

Энэ удаагийн судалгаанд харьцангуй шинэ бизнесийн нэгжүүд буюу сүүлийн 9 жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан нэгжүүд голчлон (62.6 хувь нь) оролцсон байна. Судалгаанд хамрагдсан нэгжүүдийн 34.8 хувь нь 2005 оноос хойш үйл ажиллагаа явуулж эхэлсэн нэгжүүд байгаа бол 27.8 хувь нь 2000-2004 оны хооронд, 15.4 хувь нь 1996-1999 оны хооронд, 13.2 хувь нь 1990-1995 оны хооронд 8.8 хувь нь 1990 оноос өмнө үйл ажиллагаа явуулж эхэлсэн нэгжүүд байжээ.

Бизнес эрхлэгчдийн судалгаанд оролцогчид нас, хүйсний хувьд бүхий л түвшний хүмүүс байгаа бол боловсрол, гэр бүлийн байдлын хувьд дээд боловсролтой, гэрлэсэн, хүүхэдтэй хүмүүс давамгайлжээ.

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 50.6 хувь нь эмэгтэй, 49.4 хувь нь эмэгтэй хүмүүс байлаа. Судалгаанд хамрагдагсдын дундаж нас 45 байгаа бол хамгийн бага нь 21, хамгийн ахмад нь 71 настай бизнес эрхлэгч судалгаанд хамрагдсан байна.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 30.2 хувь нь 40-49 насны, 22.1 хувь нь 30-39 насны, 21.6 хувь нь 50-59 насны, 11.6 хувь нь 20-29 насны хүмүүс байсан бол 14.6 хувь нь 60 болон түүнээс дээш насны хүмүүс байжээ.

Энэ удаагийн судалгаанд дээд боловсролтой бизнес эрхлэгчид голчлон оролцлоо. Судалгаанд оролцогчдын 79.7 хувь нь дээд боловсролтой, үлдсэн 20.3 хувь нь бүрэн бус болон бүрэн дунд

боловсролтой иргэд байжээ. Дээд боловсролтой бизнес эрхлэгчдийн 47.3 хувь нь хоёрдах боловсрол, өөр мэргэжил эзэмшсэн гэж хариулсны дотор 38.4 хувь нь удирдлагын, 19.8 хувь нь санхүү нягтлан бодох бүртгэлийн, 10.5 хувь нь хэлний чиглэлээр давтан сургалтанд хамрагджээ.

Гэр бүлийн байдлын хувьд судалгаанд оролцогчдын 88.3 хувь нь гэр бүлтэй бол 11.7 хувь нь ганцаараа амьдардаг, гэрлэж байгаагүй хүмүүс байв. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 91.9 хувь нь хүүхэдтэй хүмүүс байжээ. Судалгаанд оролцогчдын ам бүлийн дундаж тоо 4 байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 29.4 хувь нь 4 ам бүлтэй, 23.2 хувь нь 5 ам бүлтэй гэр бүл байжээ.

Судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж орлого 712.5 мянган төгрөг байна. Гэхдээ энд судалгаанд оролцогчид өрхийн сарын орлогоо үнэн зөв хэлэхийг хүсдэггүй, бууруулж хэлдэг зүй тогтол байдгийг анхаарч үзэх хэрэгтэй.

Судалгаанд оролцогчдын 88.8 хувь нь тухайн орон нутагтаа төрсөн цагаасаа болон 5 ба түүнээс жилээр амьдарч байгаа хүмүүс байгаа бол үлдсэн 11.2 хувь сүүлийн 5 жилийн хугацаанд шилжин ирсэн хүмүүс байжээ.

2.3.2 Бизнесийн үйл ажиллагааны төлөв байдал

Судалгаанд оролцогчдын дийлэнх хэсэг сүүлийн хоёр жилийн хугацаан дахь бизнесийн үйл ажиллагаандаа сайн дүн тавьж, ирээдүйдээ өөдрөг итгэлтэй байна. Судалгаанд оролцогчдын 45.1 хувь нь сүүлийн хоёр жилийн хугацаанд бизнесийн үйл ажиллагаа нь өссөн гэж хариулсан бол 31.6 хувь нь хуучин хэмжээндээ байна, 10.5 хувь буурсан гэж үзжээ.

Түүнчлэн “Та өөрийн бизнесийн үйл ажиллагааны хувьд ойрын нэгээс хоёр жилд ямар төлөвлөгөөтэй байна вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 69.4 хувь нь өргөжих бодолтой байна гэсэн өөдрөг хариултыг өгчээ. Харин 23.5 хувь нь “байгаа түвшиндээ яаж ийгээд тогтох байх”, “бизнесээ бага зэрэг хумих байх”, “орхих байх” гэсэн өөдрөг бус хариултыг өгчээ.

Сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа эрчимжиж, бизнес эрхлэгчид тэр хэмжээгээр банк санхүүгийн байгууллагаас зээл авч бизнесийн үйл ажиллагаандаа хөрөнгө оруулах болжээ. Судалгаанд оролцогчдын 74.8 хувь нь бизнесийн үйл ажиллагаандаа зориулж ямар нэгэн зээл авсны дотор 94.6 хувь нь арилжааны банкуудаас зээл авчээ.

2.3.3 Төр болон бизнесийн хоорондын харилцаа

Бизнес эрхлэгчдийн зах зээлийн нэг хэсэг төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болж байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээрх зэс, алтны үнэ өндөр байсантай холбоотойгоор улсын нэгдсэн төсвийн орлогын хэмжээ нэмэгдэж, тэр хэмжээгээр улсын төсвийн зарлага, түүний дотор хөрөнгө оруулалтын зардал нэмэгдсэн ба “Үдийн цай хөтөлбөр” зэрэг олон төсөл, хөтөлбөрийг улсын төсөв болон зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлж ирсэн төрийг томоохон худалдан авагч болгон хувиргасан юм. 2008 оны эхний 11 сарын байдлаар улсын нэгдсэн төсвөөс 571.2 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд

төсөвлөснөөс 443.5 тэрбум төгрөгийг зарцуулаад байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.5 дахин нэмэгдсэн байна.

Судалгаанд оролцогчдын 27.6 хувь нь төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагад бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлдэг гэж хариулсан бол 24.3 хувь нь зарим тохиолдолд нийлүүлдэг гэж хариулсан байна. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ байнга болон зарим тохиолдолд төрийн байгууллагад нийлүүлдэг бизнесийн нэгжүүдийн 51.9 хувь нь сүүлийн нэг жилд сарын борлуулалтынхаа 10 хүртэл хувьтай тэнцэх бүтээгдэхүүн үйлчилгээг энэ төрлийн худалдан авагчид нийлүүлсэн бол 30.1 хувь нь 11-40 хүртэл хувийг нийлүүлжээ.

Судалгаанд оролцсон барилга угсралт, засвар үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүдийн 57.7 хувь нь, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүдийн 53.3 хувь нь, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүдийн 40.0 хувь нь төрийн байгууллага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагад байнга бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлдэг гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 32.8 хувь нь сүүлийн хоёр жилийн хугацаанд тендер, дуудлага худалдаанд оролцсон гэж хариулсан бол барилга угсралт, засвар үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүдийн 78.6 хувь нь, аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүдийн 55.6 хувь нь сүүлийн хоёр жилийн хугацаанд тендерт оролцжээ.

Тендер, дуудлага худалдаанд оролцсон нэгжүүдийн 13.1 хувь нь нэг сарын өмнө, 48.8 хувь нь нэг сараас хагас жилийн өмнө, 38.1 хувь нь хагас жилээс хоёр жилийн өмнө тендер, дуудлага худалдаанд оролцжээ. Тэдний 48.1 хувь нь оролцсон тендер, дуудлага худалдаандаа бүгдэд нь шалгарсан гэж хариулсан бол 23.5 хувь нь заримд нь шалгарсан, 28.4 хувь нь шалгараагүй гэж хариулжээ.

“Тендер, дуудлага худалдаа шударга болсон уу” гэсэн асуултад сүүлийн хоёр жилийн хугацаанд тендер, дуудлага худалдаанд оролцсон гэж хариулсан судалгаанд оролцогчдын 42.2 хувь нь шударга болсон гэж үзсэн бол 37.3 хувь нь шударга бус, 20.5 хувь нь хариулахад хүндрэлтэй байна гэж хариулжээ.

Нийт тендер, дуудлага худалдаанд оролцогчдын 15.2 хувь нь тендер, дуудлага худалдаанд бүгдэд нь болон заримд нь шалгарсан хэдий ч тендер, дуудлага худалдааг шударга бус явагдсан гэж үзсэн бол 2.5 хувь нь шалгараагүй боловч тендер, дуудлага шударга болсон гэж үзжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Тендер, дуудлага худалдаанд оролцогчдын тендер, дуудлага худалдаа шударга болсон эсэх талаарх үзэл бодол, нийт дүнд эзлэх хувиар

Тендерт, дуудлага худалдаанд шалгарсан уу?	Тендер, дуудлага худалдаа шударга явагдсан гэж та үзэж байна уу?			Дүн
	Тийм	Үгүй	Хариулахад хүндрэлтэй байна	
Шалгарсан	34.2	7.6	6.3	48.1
Шалгараагүй	2.5	22.8	2.5	27.8
Заримд нь шалгарч байсан	5.1	7.6	11.4	24.1
Дүн	41.8	38.0	20.3	100.0

“Та сүүлийн хоёр жилийн турш зарлагдсан тендер, дуудлага худалдаанд оролцох гэснээ больсон тохиолдол бий юу?” гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 40.5 хувь нь “тийм” гэж хариулсан байна. Тендер, дуудлага худалдаанд оролцохоос татгалзсан шалтгаануудыг бизнес эрхлэгчид хэрхэн үнэлснийг шалтгаан тус бүрээр авч үзэхэд “шалгарах эзэн нь тодорхой байсан учир” гэсэн шалтгааныг судалгаанд оролцогчдын 57.8 хувь нь, “Тендер, дуудлага худалдаанд оролцоход хэтэрхий хүндрэлтэй, маш их бичиг баримт цуглуулах болдог” гэсэн шалтгааныг 46.7 хувь нь, “Зохион байгуулагчидтай хувийн ямар ч харилцаа байгаагүй” гэсэн шалтгааныг 44.1 хувь нь, “Хээл хахуулийн хэмжээ их байсан учир” гэсэн шалтгааныг 43.4 хувь нь нэлээн бодитой гэж үзсэн нь тэргүүлэх шалтгаанууд болж байна.

Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд Монгол Улсын Засгийн газраас “40000 орон сууц” хөтөлбөр, “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд татварын хөнгөлөлтийг үзүүлж, улсын төсөв болон хандивлагч байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр жижиг дүнд, үйлдвэрлэлийг хагжүүлэх, ажлын байрны нэмэгдүүлэх чиглэлээр хөнгөлөлттэй зээл тусламжуудыг олгож ирсэн. Түүнчлэн УИХ-аас 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр “Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” хуулийг, 2008 оны 2 дугаар 6-ны өдөр “Татварын өршөөл үзүүлэх тухай” хуулийг батлан хэрэгжүүлж байгаа билээ.

Бизнесийн үйл ажиллагаан дахь төрөөс үзүүлж буй тусламж, дэмжлэгийн хувьд нийт судалгаанд оролцогчдын 8.4 хувь нь төрийн хөнгөлөлттэй зээл, тусламж, 4.7 хувь нь татварын хөнгөлөлт, ерөнхий нөхцлөөр татвараас чөлөөлөгдөх, 6.1 хувь татварын таатай хөнгөлөлт, чөлөөлөлт, 6.1 хувь нь банкны зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх, зээлийн хугацаа сунгах, 5.2 хувь нь харилцагч нарт төлөх ёстой төлбөрөөс чөлөөлөгдөх, хугацаа сунгах тусламж дэмжлэгийг авч байсан гэж хариулсан бол 32.5 хувь нь банкны бага хүүтэй урт хугацааны зээлд хамрагдсан гэж хариулжээ.

Бизнес эрхлэгчдийн талаас илүү хувь нь төрийн албан хаагчдад ямар нэгэн үйлчилгээ үзүүлж, хахууль өгдөг гэж хариулжээ. Нийт судалгаанд оролцогчдын 37.3 хахууль төлдөггүй гэж хариулсан бол 35.4 хувь нь сарын эргэлтийн хөрөнгийнхөө 10 хүртэл хувийг, 14.6 хувь нь 10-20 хувийг, 12.7 хувь нь 21 болон түүнээс дээш хувийг төрийн албан хаагчдад төлөх болдог гэж хариулжээ.

Таван бизнес эрхлэгч дүтмын хоёр нь улс төрийн нам, улс төрчдөд материаллаг тусламж, хандив үзүүлж байсан гэж хариулжээ. Нийт судалгаанд оролцогчдын 61.8 хувь нь улс төрийн нам, улс төрчдөд материаллыг тусламж, хандив үзүүлж байгаагүй гэж хариулсан бол 20.1 хувь нь зөвхөн сонгуулийн үеэр, 13.4 хувь нь тогтмол бус, 4.7 хувь нь тогтмол хандив тусламж үзүүлдэг гэж хариулжээ.

Улс төрийн нам, улс төрчдөд тусламж, хандив үзүүлж байсан гэж хариулсан судалгаанд оролцогчдын 41.8 хувь нь намын болон улс төрчдийн санаачлагаар, 36.3 хувь нь өөрийн санаачлагаар, 22.0 хувь нь найз нөхдийн санал болгосноор тусламж, хандив өгсөн гэж хариулжээ.

Бизнес эрхлэгчдийн дийлэнх нь төртэй харьцаж хамтран ажиллах сонирхолгүй байдаг нь энэ удаагийн судалгаагаар харагдлаа. “Хүмүүс бизнес эрхлэхдээ төртэй харьцааг янз бүрээр зохион байгуулдаг. Та доор доор дурьдснаас өөрийн хамгийн их санал нийлж байгааг сонгоно уу” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 56.5 хувь нь “Би аль болох төртэй харьцахыг хүсдэггүй, манай хууль журам цоорхой ихтэй, боловсронгуй биш байдаг нь ажилд их саад болдог”, 15.3 хувь нь “Надад ямар ч асуудал байдаггүй. Хэрэв хууль зөрчих болбол дараа нь асуудлыг шийдвэрлэх албан бус аргууд их байна”, 28.2 хувь нь “Би төрийн шийдвэрт нөлөөлж болох бүх арга замыг ашигладаг. Миний ашиг сонирхлын төлөө үйлчилнэ гэдэгт би итгэлтэй байх ёстой” гэсэн хариултыг сонгожээ. Судалгаанд оролцогчдын гуравны хоёр нь л төрийн шийдвэрт нөлөөлж, бизнес эрхлэгчдийн ашиг сонирхлын төлөө санал бодлоо төрийн бодлого, шийдвэрт оруулахыг зорьдог байна.

2.3.4 Бизнес эрхлэгчдийн авлигын талаарх төсөөлөл

Бизнес эрхлэгчид авлигыг янз бүрээр тодорхойлж байна. Авлигын талаарх ойлголт дээр судалгаанд оролцогчид олон тодорхойлолт дээр санал хуваагдаад байсан бөгөөд төрийн албан хаагчид иргэдээс хээл хахууль авах (13.5%), төрийн албан тушаалын эрх мэдлээр бизнес хийх (12.9%), улс төрч, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчид нэгдэн нэг бүлэг болж иргэд, улс эх орныхоо төлөө бус зөвхөн өөрсдийн төлөө үйл ажиллагаа явуулах (11.3%), өөрсөддөө ашигтай шийдвэр гаргуулахын тулд том бизнес эрхлэгчид төрийн өндөр албан тушаалтнуудыг өөрийн талд оруулах (10.6%) зэрэг тодорхойлолтуудыг харьцангуй олон бизнес эрхлэгч сонгожээ.

Бизнес эрхлэгчдийн үзэж байгаагаар авлига авсан төрийн албан хаагчийн өөрийгөө зөвтгөх эхний хоёр шалтгаан нь “Бүгд авч байна. Баригдаж мэдэгдсэн нь л би болохоос” (нийт оролцогчдын 30.7%), “Манай

удирдлага аваад байхад би яагаад авч болохгүй гэж” (нийт оролцогчдын 20.5%) зэрэг шалтгаанууд байжээ.

Авлигын талаарх мэдээлэл өгсөн хүнийг судалгаанд оролцогчдын дийлэнх нь үнэнч шударга хүн гэж тодорхойлж байна. Судалгаанд оролцогчдын 65.3 хувь нь үнэнч шударга хүн, 5.0 хувь нь матаач, 4.5 хувь нь атаархагч, 3.5 хувь нь өшөө авагч, 2.0 хувь нь мангар, 1.5 хувь нь урвагч гэж тодорхойлжээ.

Бизнес эрхлэгчид ерөнхийдөө Монгол Улсад, түүнчлэн улс төрийн болон хууль хяналтын хүрээнд аль алинд нь авлига түгээмэл үзэгдэл гэж үзжээ. Нийт судалгаанд оролцогчдын 81.9 хувь Монгол Улсад их түгээмэл, 78.7 хувь нь улс төрийн хүрээнд авлига их түгээмэл, 74.1 хувь нь хууль хяналтын байгууллагуудад авлига их түгээмэл гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдоор тодорхой нэр заасан төрийн байгууллага, институцийн авлигад автсан байдлыг үнэлүүлсэн бөгөөд судалгаанд оролцогчид газрын алба хамгийн их авлигад автсан гэж үнэлсэн бол олон нийтийн байгууллагуудыг харьцангуй бага авлигад автсан гэж үнэлжээ. Газрын албыг судалгаанд оролцогчдын 85.8 хувь, гаалийн байгууллагыг 83.5 хувь, мэргэжлийн хяналтын байгууллагыг 80.5 хувь, замын цагдаа болон УИХ-ын гишүүдийг 78.3 хувь нь авлигад харьцангуй их болон нэлээн автсан гэж үнэлжээ. Олон нийтийн байгууллагууд (17.9%), хувиараа бизнес эрхлэгчид (23.3%), хэвлэл мэдээллийн хэрэгсэл (30.3%) банкны байгууллага (39.5%) зэргийг судалгаанд оролцогчдын харьцангуй бага хувь нь авлигад автсан гэж үнэлжээ.

Бизнес эрхлэгчид авлигыг 1996 оноос хойш хамгийн их тархсан гэж үзжээ. Судалгаанд оролцогчдын 35.9 хувь нь 2000-2004 онд, 32.8 хувь нь 2004-2008 онд, 15.5 хувь нь 1996-2000 онд, 5.6 хувь нь 1992-1996 онд авлига хамгийн их тархсан гэж үзжээ.

Бизнес эрхлэгчид шүүхийн үйл ажиллагааны талаар харьцангуй доогуур үнэлгээг өгч байна. Шүүхэд танил тал, найз нөхдийн шугамаар асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 94.0 хувь нь, шүүхэд хэн их төлж чадсан нь ялдаг зуршил тогтоод байна гэдэгтэй 89.6 хувь нь, ихэнх тохиолдолд ямар нэгэн удирдах албан тушаалтан шүүгчийн гаргах шийдвэрт нөлөөлдөг гэдэгтэй 83.8 хувь нь, ихэнхи иргэд шүүхэд хандах дургуй, учир нь шүүхэд шударга ёсыг олохгүй гэдэгтэй 81.3 хувь нь санал нийлж байна гэж хариулжээ.

Шүүхэд ихэнхи иргэд хандах дургуй, учир нь албан бус зардал нь дэндүү үнэтэй гэдэгтэй 74.6 хувь нь, шүүгчдийн мэдлэг, ур чадвар муу тул асуудлыг шийдэж чаддаггүй гэдэгтэй 66.1 хувь нь, шүүгчийн цалин бага иймд тэд авлига авч эхэлсэн гэдэгтэй 61.7 хувь нь санал нийлж байна гэж хариулжээ. Гэтэл судалгаанд оролцогчдын 47.9 хувь нь л өнөөдөр иргэд шүүхэд эрхээ хамгаалуулан асуудлаа хуулийн дагуу, шударгаар шийдүүлэх боломжтой болсон гэж үзсэн бол 43.7 хувь нь шүүх хараат бус, бие дааж үйл ажиллагаагаа явуулж чаддаг гэж хариулжээ.

“Шүүх авлига, танил тал, хөндлөнгийн нөлөөнд орж шийдвэр гаргадаг гэдэгт Та итгэж байна уу” гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 62.4

хувь нь “тийм”, 18.8 хувь нь “үгүй” гэж хариулсан бол 18.8 хувь нь хариулахад хүндрэлтэй байна гэжээ.

Төр бизнес хөгжих таатай орчныг хууль эрхзүйн болон эдийн засгийн хүрээнд бүрдүүлэхгүй байгаа нь авлига үүсэх үндсэн шалтгаан болж байна гэж судалгаанд оролцогчид үзэж байна. “Манайд авлигагүйгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй байдгийн үндсэн шалтгаан нь юу байдаг вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 36.7 хувь нь “Шударга өрсөлдөөн байх нөхцөлийг төр хангаж чаддаггүй, иймд төрийн албан хаагчдад хахууль өгөх шаардлагатай болдог” гэсэн хариултыг, 22.9 хувь нь “Манай улсад хууль журам зөрчихгүйгээр бизнес эрхлэх боломжгүй. Үүний тулд хахууль өгөх шаардлагатай болдог” гэсэн хариултыг, 22.0 хувь нь “Манай улсад бизнес хамгаалагдаагүй учир авлига нь өөрийгөө хамгаалах арга юм” гэсэн хариултыг, 16.5 хувь нь “Төр бизнесийн харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчин боловсронгуй биш. Иймд далд авлигын аргуудыг ашиглах болдог” гэсэн хариултыг сонгосон байна.

Албан тушаалтнууд хахууль өгөх гарцаагүй нөхцөл байдлыг бий болгодог учраас авлига өгөхөд хүрдэг гэж бизнес эрхлэгчдийн харьцангуй олонх хувь нь хариулж байна. Судалгаанд оролцогчдын 45.1 хувь нь албан тушаалтнууд хахууль өгөх гарцаагүй нөхцөл байдлыг бий болгодог, 13.3 хувь нь хоёр тал хоёулаа эхнээсээ энэ тохиодолд авлига зайлшгүй гэдгийг мэддэг, 11.9 хувь нь асуудлыг шийдвэрлэх өөр арга зам байдаггүй гэж хариулжээ.

Төрийн өндөр албан тушаалтнууд шударга бус, төрийн албанд дандаа ашиг хайж, баяжихын тулд орж ирдэг гэдэгтэй бизнес эрхлэгчид санал нийлж байна. Судалгаанд оролцогчдын 53.9 хувь нь төрийн өндөр албан тушаалтнуудын ихэнхи нь хахууль авдаг, 23.2 хувь нь төрийн өндөр албан тушаалтнуудын бага хувь нь авлига авдаг, 7.9 хувь нь тал хувь нь авлига авдаг гэж хариулсан бол 5.7 хувь нь төрийн өндөр албан тушаалтнууд шударга бус, төрийн албанд дандаа ашиг хайж, баяжихын тулд орж ирдэг гэдэгтэй санал нийлэхгүй байгаагаа илэрхийлжээ.

Бизнес эрхлэгчид хахууль өгч асуудлыг шийдвэрлэх нь манай амьдралын салшгүй нэг хэсэг гэж үзэж байгаа хэдий ч үүнээс татгалзах хэрэгтэй гэж үзэж байна. “Манайд иргэд өөрсдийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хахууль өгдөг гэдэгтэй хир санал нийлэх вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 31.7 хувь нь үүнээс зайлсхийж болно, тэгэхдээ хахууль өгөх нь хялбар байдаг, 29.1 хувь нь үүнээс татгалзах хэрэгтэй, учир нь авлига нь хүмүүсийн амьдралыг сүйтгэж байна, 27.0 хувь нь энэ нь манай амьдралын салшгүй хэсэг, үүнийг хийхгүйгээр юу ч шийдвэрлэж чадахгүй гэж хариулсан бол 6.1 хувь нь манайд иргэд өөрсдийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хахууль өгдөг гэдэгтэй санал нийлэхгүй байгаагаа илэрхийлжээ.

Төрийн үйл ажиллагааны доголдол нь авлига үүсэх үндсэн шалтгаан нөхцөл болж байна гэж бизнес эрхлэгчид үзжээ. Судалгаанд оролцогчдын 40.3 хувь нь төрийн үйл ажиллагааны доголдлоос болж бий болдог, 25.8 хувь нь авлигын шалтгаан нөхцөл нь бидний зах зээлд шилжих явцад бий болсон, 17.0 хувь нь улс төрийн буруу тогтолцооны улмаас бий болдог, 8.8

хувь нь авлигын шалтгаан нөхцөл нь манай түүх, уламжлалт харилцаанд байгаа гэж хариулжээ.

Хувьчлалыг ил тод, шударга явуулдаггүй (86.2%), төрийн үйл ажиллагаа нь бизнесийн үйл ажиллагаатай холилдох (79.4%), хууль тогтоомжийн тодорхой бус байдал нь албан тушаалтнуудыг дураараа авирлах бололцоог олгодог (79.0%), төрийн дээд удирдлага авлигад автсан (77.0%), улс төрчид болон төрийн албан тушаалтнуудын ёс зүйгүй байдал (75.4%) зэрэг нь авлига үүсэхэд чухал нөлөөтэй гэж үзжээ. Энд дурьдсан шалтгаан нөхцлүүдийг бүгдийг нь судалгаанд оролцогчдын тавиас дээш хувь нь авлига үүсэхэд чухал нөлөөтэй гэж үзсэн бол түүхэн талаас нь авч үзвэл авлига нь Монголчуудын амьдралын хэв шинжийн нэг хэсэг болж ирсэн гэсэн шалтгааныг судалгаанд оролцогчдын зөвхөн 23.8 хувь нь чухал гэж үзсэн байна.

Судалгаанд оролцогчид бүх нийтээрээ тэмцэж байж авлигыг үгүй болгож чадна гэдэг дээр санал нийлж байна. Судалгаанд оролцогчдын 67.6 хувь нь “авлигатай бид бүгдээрээ тэмцэж байж үгүй болгож чадна”, 18.8 хувь нь “авлигыг хэрэв улс төрчид хүсвэл үгүй болгож чадна” гэж хариулсан бол 9.4 хувь авлига урьд нь ч байсан, цаашдаа ч байх болно гэсэн өөдрөг бус хариултыг өгчээ.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн тал хувь нь авлигатай тэмцэхэд өөрийн гар биеэр оролцоход бэлэн байна. “Хэрэв манай улсад урт хугацааны авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлбэл, Та дор дурьдсан бодлогуудаас алийг сонгох байсан бэ?” гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 47.9 хувь нь “би өөрөө оролцоно” гэж авлигатай тэмцэхэд бэлэн байгаагаа илэрхийлж, 23.3 хувь нь “Юу болохыг харзнана” гэж төвийг сахисан байр суурийг илэрхийлсэн бол 19.5 хувь нь “Энэ ямар ч үр дүнд хүрэхгүй, ээлжит компани ажил болох болно” гэж сөрөг, өөдрөг бус байр суурийг баримталж байгаагаа илэрхийлжээ.

“Дээр дурьдсан авлигын эсрэг ажил эхлэлээ гэж бодоход та ямар хэлбэрээр оролцох вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 30.9 хувь нь “Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг дэмжинэ”, 28.4 хувь нь “Үйл ажиллагаанд нь гар бие оролцоно”, 21.8 хувь нь “Өөрийн компанид авлигын эсрэг ёс зүйг бий болгоно”, 12.6 хувь нь “Бодлого боловсруулан хэрэгжүүлж байгаа улс төрийн намыг дэмжинэ”, 4.1 хувь нь “Мөнгөн хөрөнгөөр санхүүжүүлнэ” гэж хариулжээ.

Бизнес эрхлэгчид авлигыг бий болгож буй шалтгаан нөхцөлийг үгүй болгож, шударга бус удирдагч нарыг шударга удирдагч нараар солих нь авлигатай тэмцэх хамгийн үр дүнтэй арга гэж үзжээ. “Төрөөс ямар бодлого авч хэрэгжүүлбэл Та үнэхээр авлигатай тэмцэж байна хэмээн хүлээн зөвшөөрөх вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчид “Авлигад өртсөн албан тушаалтныг халж, дахин төрд ажиллуулахгүй болговол” (21.4%), “Авлига үүсэж буй нөхцөлийг үгүй болгобол” (12.4%), “Гэмт хэрэг үйлдсэн төрийн өндөр албан тушаалтнуудын шүүх хурлыг нээлттэй хийж эхэлбэл” (11.0%), “Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлж эхэлбэл” (9.7%), “Хууль журмыг ягштал биелүүлж эхэлбэл” (6.2%) зэрэг хариултыг голчлон сонгожээ.

“Танд манай улс дахь авлигатай тэмцэх хөтөлбөрийг боловсруулах боломж олдсон гэж бодъё. Та, хөтөлбөрийг хамгийн оновчтой илэрхийлэх санааг сонгоно уу?” гэсэн асуултад нийт оролцогчдын 39.0 хувь нь “Авлигыг бий болгож буй шалтгаан нөхцөлийг үгүй болгох /эдийн засгийн, хууль эрх зүйн гэх мэт”, 26.9 хувь нь “Шударга бус удирдагч нарыг шударга удирдагч нараар солих”, 21.2 хувь нь “Авлигад автагсадыг хатуу шийтгэх”, 10.6 хувь нь “АТГ-ын үйл ажиллагааг бүх нийтээрээ дэмжих” гэж хариулжээ. Харин судалгаанд оролцогчдын 1.9 хувь нь “Ямар ч стратеги нэмэр болохгүй, авлигатай тэмцээд үр дүн гарахгүй” гэж хариулсан байна.

Авлигын талаарх нэргүй мэдээлэл авах системийг манайд нэвтрүүлэхийг бизнес эрхлэгчид дэмжиж байгаа хэдий ч нэргүй мэдээллээр шударга хүнийг хэлмэгдүүлэх эрсдэлтэй, нууцлалыг хангахад хүндрэлтэй гэж болгоомжилж байна. Судалгаанд оролцогчдын 36.5 хувь нь “хэрэв хэн нэгэн авлигын хэргийн талаар мэдээлэлтэй бол нэргүй мэдээлэл өгөх хэрэгтэй”, 19.3 хувь нь “нэргүй мэдээллийн нэрээр шударга хүнийг хэлмэгдүүлэх боломжтой”, 15.5 хувь нь “хэрэгтэй гэдэгтэй санал нийлж байна”, 13.8 хувь нь “энэхүү систем нь үр ашиггүй, учир нь нууцлалыг хадгалах маш хэцүү” гэж хариулжээ.

Бизнес эрхлэгчид авлигын талаарх мэдээллийг тааралдсан үед нь уншиж, үзэж сонирхдог байна. Судалгаанд оролцогчдын 62.1 хувь нь тааралдахаар нь уншдаг, үздэг, сонсдог, 16.1 хувь нь би тэдэнд итгэдэггүй учир, энэ талаар сонирхдоггүй, 10.9 хувь нь өөрөө хайж олж мэддэг, 5.7 хувь нь надад сонин биш гэж хариулжээ.

Авлигын талаарх мэдээллийг олж авах гол эх үүсвэр нь зурагт болон сонин болж байна. Судалгаанд оролцогчдын 36.7 хувь нь зурагтаас, 35.1 хувь нь сониноос, 17.8 хувь нь найз нөхөд, хамт ажилладаг хүмүүстэйгээ ярилцан авлигын талаарх мэдээллийг олж авдаг гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 35.8 хувь нь долоо хоногоос нэг жилийн өмнөх хүртэл хугацаанд төрийн албан хаагч, албан тушаалтныг бизнесийн асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар нэг хэлбэрээр “дэмжсэн” байна. Харин судалгаанд оролцогчдын 35.8 хувь нь манай компани ийм юм хэзээ ч хийж байгаагүй гэж хариулсан бол 28.4 хувь нь хариулахад хүндрэлтэй байна гэжээ.

Төрийн албан хаагч, албан тушаалтанд “дэмжлэг” үзүүлсэн бизнес эрхлэгчдийн 45.3 хувь нь орон нутгийн албан тушаалтан, 7.0 хувь нь орон нутгийн албан тушаалтан, 5.8 хувь нь УИХ-ын гишүүн, 4.7 хувь нь яамны албан тушаалтанд, 3.5 хувь нь агентлагийн албан тушаалтанд, 2.3 хувь нь засгийн газрын гишүүн, 9.3 хувь бусад түвшний албан тушаалтанд “дэмжлэг” үзүүлсэн гэж хариулсан бол 22.1 хувь нь хариулахад хүндрэлтэй байна гэжээ.

Төрийн албан хаагч, албан тушаалтанд “дэмжлэг” үзүүлсэн бизнес эрхлэгчид дунджаар сарын орлогынхоо 8.7 хувийг энэхүү “дэмжлэг”-т зарцуулсан гэжээ. Эдгээр бизнес эрхлэгчдийн 36.4 хувь нь сарын орлогынхоо 0.5 хувийг, 27.3 хувь нь 1-5 хүртэлх хувийг, 16.7 хувь нь 10 хувийг, 9.1 хувь нь 20 хувийг, 10.6 хувь нь 40 ба түүнээс дээш хувийг

бизнесийнхээ асуудлыг шийдвэрлэхээр төрийн албан хаагч, албан тушаалтанд зарцуулжээ.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 17.6 хувь нь сүүлийн хоёр жилийн хугацаанд ямар нэг асуудлаар шүүхэд хандаж байсан гэж хариулжээ. Шүүхэд ямар нэг асуудлаар хандаж байсан бизнес эрхлэгчдийн 13.0 хувь нь манай хэргийн шийдвэрлэлтэд оролцож байсан шүүгч, прокурор болон бусад талаас ямар нэгэн байдлаар манайд нааштай шийдэхийн тулд баярласны илэрхийлэл шаардсан тохиолдол гарч байсан гэж хариулжээ. Шаардаж байсан мөнгөний хэмжээ нь бизнес эрхлэгчдийн сарын орлогын дунджаар 1.6 хувьтай тэнцүү байжээ.

Улс төрчид авлигаас ашиг хонжоо олдог учраас улс төрчид, өөрсдөд нь ашигтай учраас том бизнес эрхлэгчид авлигыг устгах хүсэл сонирхол байдаггүй гэж судалгаанд оролцогчдын олонх нь үзжээ.

Улс төрчид авлигаас ашиг хонжоо олдог учраас улс төрчдөд авлигатай тэмцэх чин сэтгэлийн хүсэл зориг байдаггүй гэдэгтэй судалгаанд оролцогчдын 82.5 хувь нь, өөрсдөд нь ашигтай байдаг учраас том бизнес эрхлэгчид төр, засгийн хүрээнд авлигачдыг байлгах сонирхолтой байдаг гэдэгтэй 79.3 хувь нь санал нийлж байна гэж хариулжээ.

Шүүхийн тогтолцоо авлигатай тэмцэхэд ач холбогдолтой боловч өөрөө авлигад автсан гэдэгтэй судалгаанд оролцогчдын 72.6 хувь нь санал нийлж байна гэж хариулсан бол шүүхийн хараат бус байдал алдагдсан гэдэгтэй 69.4 хувь нь санал нийлж байна гэжээ.

Мөнгөтэй хүнд хууль үйлчилдэггүй, юу ч ярьж байсан гэсэн мөнгө бүхнийг шийднэ гэдэгтэй судалгаанд оролцогчдын 79.7 болон 62.7 хувь нь санал нийлж байна гэжээ. Гэтэл өнөөгийн цагт хуулийг хэн ч сахидаггүй, иймд хууль сахих нь тэнэг зүйл гэдэгтэй судалгаанд оролцогчдын зөвхөн 36.7 хувь санал нийлж байна гэж хариулжээ. Эндээс бизнес эрхлэгчид мөнгөтэй, эрх мэдэлтэй мэдэлтэй хүмүүст хууль үйлчилдэггүй байгаа гэдэгтэй санал нийлж байгаа хэдий ч бүх нийтээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, хуулийг чандлан сахидаг байхыг хүсэж байгаа нь харагдаж байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд өөрийн албан тушаалаа урвуулан ашигладаг, тэдэнд хэт их эрх мэдэл олгосон, тэд чин үнэнчээр ажилладаггүй гэдэгтэй судалгаанд оролцогчдын 71.8-74.9 хувь нь санал нийлж байна гэж хариулжээ. Харин улс төр, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа хаалттай байдаг гэдэгтэй 70.5 хувь нь санал нийлжээ.

Улс төрд томоохон бизнес эрхлэгчдийн нөлөө байж, бизнес эрхлэгчид зөвхөн өөрийн бизнесээ хөгжүүлэхийн тулд улс төрд ордог гэдэгтэй судалгаанд оролцогчдын 76.9 болон 81.5 хувь нь санал нийлж байна гэж хариулжээ.

Газрын зөвшөөрөл, лицензийг албан тушаалтнууд хуулийн дагуу бус өөрийн үзэмжээр олгодог, төрийн өмчийн хувьчлал ихэнхдээ хууль бус явагддаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 79.0-81.7 хувь санал нийлж байна гэжээ.

Цалин бага тул авлига авах шаардлага тулгардаг гэдэгтэй харьцангуй бага хувь буюу 56.5 хувь нь санал нийлж байгаа бизнес эрхлэгчид төрийн албан хаагчдын цалин хангамж доогуур бус гэж үзэж байгааг харуулж байна.

Хувийн хэвшилд тавих төрийн хяналт муу гэдэгтэй мөн тийм ч олонх нь санал нийлсэнгүй. Судалгаанд оролцогчдын тал хувь нь буюу 50.3 хувь нь хувийн хэвшилд тавих төрийн хяналт хангалттай байгаа гэж үзжээ.

Хуулийн цоорхой ашиглан хүн өөртөө ашигтайгаар тайлбарлан урвуулан ашигладаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 74.0 хувь санал нийлж байна гэжээ. Түүнчлэн ёс зүй, ёс суртахууны доройтол байдаг гэдэгтэй 71.5 хувь санал нийлж байна гэж хариулжээ.

2.3.5 Бизнесийн орчин

Монгол Улсад бизнес эрхлэхэд олон төрлийн хүндрэл бэрхшээл учирч байна. Бизнес эрхлэгчид тээврийн зардал өндөр байдаг (77.8%), үнийн хөөрөгдөл (76.1%), урт хугацааны зээлийн хүү өндөр (75.8%), төрийн албаны хүнд суртал (74.9%), хяналтын байгууллагуудаас ойр ойрхон шалгалт явуулж, олон төрлийн бичиг баримт шаарддаг (71.5%) зэргийг бизнес эрхлэхэд учирч буй голлох хүндрэл бэрхшээлүүд гэж үзжээ.

Түүнчлэн цахилгаан эрчим хүчний зардал өндөр, татвар өндөр байдаг, төрөөс эдийн засгийн талаар явуулж буй бодлого тодорхойгүй байдаг, шударга бус өрсөлдөөн зэрэг нь бизнес эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлүүдийн нэг хэсэг болж байна.

Татвар төлөгчдийн хувьд аль болох бага татвар төлөх сонирхолтой байдаг ч төрөөс бизнесийг хамгаалж, түүнийг хөгжих таатай орчинг бүрдүүлсэн тохиолдолд тэдний татвар төлөх сонирхол нэмэгдэнэ гэдгийг судалгааны дүн харууллаа. Одоогийн нөхцөл байдалд бизнес эрхлэгчдийн 91.9 хувь нь 10 хүртэл хувийн татвар, зөвхөн 8.1 хувь нь 10-20 болон 20-30 хувийн татвар төлөхөд бэлэн байна гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 37.7 хувь нь төрөөс эдийн засагт нөлөөлж буй сөрөг нөлөөллүүд багассан тохиолдолд 10-20 хувийн, тус бүр 2.8 хувь нь 20-30 болон 30-40 хувийн татвар төлөхөд бэлэн байна гэж хариулжээ.

Өмчийн бүх хэлбэрийг төрөөс хамгаалах үндсэн үүргээ хэрэгжүүлж байгаа нөхцөлд судалгаанд оролцогчдын 30.8 хувь нь 10-20 хувийн, 7.5 хувь нь 20-30 хувийн, 3.7 хувь нь 30-40 хувийн татвар төлөхөд бэлэн байна гэж хариулсан бол төрөөс тогтвортой, шат дараалсан, үр ашигтай авлигатай тэмцэх үйл ажиллагаа явуулж буй нөхцөлд 33.3 хувь нь 10-20 хувийн, 9.2 хувь нь 20-30 хувийн, 8.3 хувь нь 30-40 хувийн татвар төлөхөд бэлэн байна гэж хариулжээ.

Бизнес эрхлэгчид бүх хууль журмыг мөрдөж шударгаар өрсөлдөх сонирхолтой байдаг хэдий ч хууль журмыг зөрчих, албан тушаалтнуудыг хахуульдах замаар асуудлаа шийдвэрлэхээс татгалзахгүй бизнес эрхлэгчид байдаг. Судалгаанд оролцогчид өнөөгийн нөхцөлд шударгаар өрсөлддөг бизнес эрхлэгчийн амжилтаас шударга бусаар дээрх арга замаар асуудлаа шийдвэрлэдэг бизнес эрхлэгчдийн амжилт илүү байдаг гэж үзжээ. Шударгаар өрсөлддөг бизнес эрхлэгчийн амжилтыг шударга бусаар өрсөлддөг бизнес эрхлэгчийн амжилттай харьцуулахад 28.2 хувь нь хэд

дахин их, 8.1 хувь нь ойролцоогоор 100 хувь илүү, 16.1 хувь нь ойролцоогоор 50 хувь илүү, 9.4 хувь нь ойролцоогоор 20 хувь илүү гэж хариулсан бол 20.1 хувь нь л тэдний амжилт ерөнхийдөө адилхан, 18.1 хувь нь харин ч алдаж байна гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл, шударгаар бусаар болон шударгаар өрсөлддөг бизнес эрхлэгчдийн харьцаа 61.7:38.7 болж шударга бусаар бизнес эрхлэх илүү амжилтанд хүрнэ гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь үзжээ.

Өрсөлдөөнд өөрийн байр сууриа хадгалж үлдэх, бизнес эрхлэхэд төрөөс ирж буй дарамт шахалтыг давж гарах гол арга зам нь төрд өөрийн төлөөлөлтэй байж, тэднээр бизнесээ хамгаалуулах явдал юм гэж бизнес эрхлэгчид үзэж байна. “Та өөрийн өрсөлдөгч нараа юу гэж тодорхойлдог вэ” гэсэн асуултад судалгаанд оролцогч бизнес эрхлэгчдийн 32.9 хувь нь “Миний өрсөлдөгч нарын ард нөлөө бүхий төрийн эрх мэдэлтнүүд байна. Надад тэдэнтэй өрсөлдөхөд хүнд байдаг” гэсэн хариултыг, 5.0 хувь нь “Миний өрсөлдөгч нарыг ердийн дээрэмчдээс ялгах зүйл байхгүй” гэсэн хариултыг сонгосон бол эсрэгээр 23.7 хувь нь “Зонхилох хэсэг нь хүндэтгэл хүлээх компаниуд, бид шударгаар өрсөлддөг” гэсэн хариултыг, 26.5 хувь нь “Надад тэдний талаар муу үг хэлэхэд хэцүү байна. Хэрэв би тэдэнд ялагдаж байгаа бол тэд надаас илүү ажиллаж чадаж байна” гэж хариулжээ. Шударгаар өрсөлддөг гэж хариулж буй судалгаанд оролцогчдын эзлэх хувь 50.2 болж байна.

Манайд бизнес эрхлэхэд төрөөс байнга дарамт шахалт ирдэг гэсэн яриа байдаг. Энэхүү дарамт шахалтыг давж гарахад ямар арга замыг сонгох вэ гэсэн асуултыг судалгаанд оролцогчдоос асуусан юм. Судалгаанд оролцогчдын 18.2 хувь нь “төрд өөрийн талын төлөөлөлтэй байх”, 13.0 хувь нь “төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрчид, УИХ-ын гишүүдийн дунд сайн танилтай болохыг эрмэлзэх”, 11.8 хувь нь “Мөнгө төлж асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байх”, 9.2 хувь нь “Надад миний танил төрийн албан хаагч нар тусалдаг, заримдаа би тэдэнд тусалдаг учир”, 8.1 хувь нь “манайд бүх асуудлыг зохицуулж болдог, иймд өөрийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хууль зөрчилгүй хуулийн цоорхойг ашигладаг” гэж хариулсан бол 18.0 хувь нь “би цоорхой ихтэй, учир дутагдалтай хууль журмыг аль болох боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг”, 10.9 хувь нь “хүчтэй хамтрагч олж авдаг” гэж хариулжээ.

Төрийн гүйцэтгэх үүргүүдийн нэг нь төрөөс бизнесийн үйл ажиллагааг дэмжиж, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх явдал хэдий ч бизнес эрхлэгчид төр энэ үүргээ биелүүл чадахгүй байгаа нь эргээд бизнес эрхлэхэд учирч аюул эрсдэл болж байна гэж үзэж байна. Бизнес эрхлэхэд учирч буй голлох таван аюул эрсдлээр бизнес эрхлэгчид төрийн албан хаагчдын ур чадваргүй, мэдлэггүй байдал (17.7%), төрийн байгууллагын хүнд суртал (16.3%), авлига (14.3%), улс төрийн тогтворгүй байдал (12.5%), төрийн албаны олон шат дамжлага (12.2%) зэргийг дурьджээ.

Хувийн хэвшил хөгжихөд төрөөс үзүүлж буй дарамтуудын эхний байранд бизнес эрхлэгчид хяналтын байгууллагуудын хэт их дарамт, төрийн албан хаагчид “өөрийн” аж ахуйн нэгжийг хамгаалах бодлого

явуулдаг, орон нутагт төрийн эрх мэдэл том хүчтэй хувийн хэвшлийн компаний эрх ашигт үйлчилж эхэлдэг, шүүх шударгаар ажиллаж чаддаггүй зэргийг нэрлэж байна.

Бизнес эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаанд нь хамгийн их саад бэрхшээл учруулдаг байгууллагаар татварын байгууллага (судалгаанд оролцогчдын 30.8 хувь), лиценз, зөвшөөрөл олгох байгууллага (19.9%), Орон нутгийн байгууллага буюу аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг захиргаа (18.6%) зэргийг дурьджээ.

Судалгаанд оролцогчдын 25.3 хувийг хагас жилээс нэг жилийн өмнө, 20.1 хувийг нэг сараас хагас жилийн өмнө, 20.1 хувийг долоо хоногоос нэг сарын дотор 16.7 хувийг нэг жилийн өмнө хяналтын байгууллагууд шалгасан бөгөөд 40.1 хувийг нь татварын байгууллага, 11.7 хувийг нь худалдааны хяналтын байгууллага, 7.4 хувийг аудитын байгууллага, 5.6 хувийг нийгмийн даатгалын байгууллага болон засаг захиргааны байгууллага шалгажээ.

“Тухайн үед хяналтын байгууллагын албан хаагчдаас авлига шаардах, аргагүй байдалд оруулах зэрэг асуудалтай тулгарсан уу” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 11.6 хувь нь “тийм”, 23.8 хувь нь “зарим тохиолдолд” гэж хариулсан бол 64.6 хувь нь “үгүй” гэж хариулжээ.

Бизнес эрхлэгчид голчлон орон нутгийн засаг захиргааны, хууль тогтоох, дүрэм журам боловсруулах, орон нутгийн хууль хяналтын байгууллагын шийдвэрт албан бусаар нөлөөлөхийг оролдож байжээ.

Бизнесийнхээ асуудлыг шийдвэрлэхийн тулд уг асуудлаар төр засгийн байгууллагад хандаа байсан бизнес эрхлэгчдийн 48.5 хувь нь орон нутгийн засаг захиргааны шийдвэрт, 12.1 хувь хууль тогтоох, 12.1 хувь нь журам, дүрэм боловсруулах байгууллагын шийдвэрт, 9.1 хувь нь орон нутгийн хууль хяналтын байгууллагын шийдвэрт, тус бүр 6.1 хувь нь хууль хяналтын байгууллагын шийдвэрт болон орон нутгийн шүүхийн байгууллагын шийдвэрт, 4.5 хувь нь дээд шүүх, шүүх, арбитрийн шүүхийн шийдвэрт албан бусаар нөлөөлөхийг оролдож байжээ.

2.3.6 Бизнес эрхлэгчдийн итгэл үнэмшил

Бизнес эрхлэгчид өөрсдийгөө уйгагүй хөдөлмөрч, хөгжлийн хөдөлгүүр гэж үздэг байна. Бизнес эрхлэгчийг судалгаанд оролцогчдын 61.7 хувь нь уйгагүй хөдөлмөрч, 22.6 хувь нь хөгжлийн хөдөлгүүр гэж үзжээ.

Гаалийн ажилтныг судалгаанд оролцогчдын 34.8 хувь нь, цагдааг 32.5 хувь нь, 27.3 хувь нь хяналтын байцаагч нарыг, 19.6 хувь нь төрийн албан хаагчдыг дайсан гэж үздэг гэж хариулжээ.

Манай нийгэмд тулгараад байгаа асуудлуудаас хамгийн их санаа зовоосон гурван асуудлаар үнийн өсөлт; төрийн албан тушаалтнуудын ашиг хожоо хайсан байдал, авлига, хүнд суртал; ажилгүйдэл зэргийг сонгожээ. Нийт судалгаанд оролцогчдын 25.0 хувь нь үнийн өсөлтийг, 15.6 хувь нь төрийн албан тушаалтнуудын ашиг хожоо хайсан байдал, авлига, хүнд суртал, 15.4 хувь нь ажилгүйдлийг сонгожээ.

Ихэнх бизнес эрхлэгчид хүмүүст итгэж болохгүй, болгоомжтой харьцах хэрэгтэй гэдэг байр суурийг баримталдаг байна. Судалгаанд

оролцогчдын 73.4 хувь нь хүмүүстэй харьцахдаа болгоомжтой байх хэрэгтэй гэж хариулсан бол 19.7 хувь нь хүмүүст итгэж болно гэж хариулжээ.

Бизнес эрхлэгчдийн үзэж байгаагаар хамгийн итгэл даасан байгууллагаар (бүрэн итгэдэг, итгэдэг гэсэн хариулт өгсөн судалгаанд оролцогчдын эзлэх хувийн жингээр нь эрэмбэлж үзэхэд) бизнесийн байгууллагууд (67.3%), батлан хамгаалах, зэвсэгт хүчин (67.0%), боловсролын байгууллага (61.1%), хэвлэл мэдээллийн хэрэгсэл (56.3%) зэрэг байгууллага, институциуд орж байгаа бол бизнес эрхлэгчдийн итгэл хүлээгээгүй байгууллагуудад улс төрийн намууд (17.2%), гаалийн байгууллага (21.8%), газрын алба (24.4%) орж байна.

“Засгийн газрын үүрэг бол хүн болгоныг ажилтай болгох” гэдэгтэй судалгаанд оролцогчдын 64.9 хувь нь “санал нийлж байна” гэж хариулсан бол “үг хэлэх эрх нь дур зоргоороо авирлахад хүргэлээ” гэдэгтэй 53.5 хувь нь “санал нийлж байна” гэж хариулжээ. Бизнес эрхлэгчдийн хувьд сонгуульд хариуцлагатай оролцож, сонгох гэж буй хүнээ сайн таньж сонгодог гэсэн дүгнэлтийг судалгааны дүнгээс хийж болохоор байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 67.9 хувь нь “Би сонгууль өгч байхдаа хэний төлөө сонгууль өгч буйгаа мэддэггүй” гэдэгтэй санал нийлэхгүй байна гэж хариулжээ. Гэсэн хэдий ч “Ардчилал өрнөснөөр бид өнөөдөр хамгийн шилдэг хүмүүсээ сонгож чадаж байна” гэдэгтэй 73.2 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулжээ.

“Юу ч ярьж байсан мөнгө бол бүхнийг шийднэ” гэдэгтэй судалгаанд оролцогчдын 64.7 хувь нь, “Өнөөдөр хэн ч хуулийг мөрдөхгүй байна. Иймд хууль мөрдөх нь тэнэг ба гэнэн зүйл юм” гэдэгтэй 64.9 хувь нь санал нийлж байна гэж хариулжээ.

“Том бизнес эрхлэгчид, банкныхан эрх мэдэл, нөлөө ихтэй болж байна”, “бид нарын сонгосон гишүүд маш хурдан бидний хүсэн хүлээж буй зүйлийг мартдаг” гэдэгтэй маш өндөр хувь буюу харгалзан 86.7 хувь, 85.8 хувь нь санал нийлж байна гэж хариулжээ.

“Бид өнөөдөр капиталист нийгэмд амьдарч байгаа юм чинь хүн хүндээ чоно, хүчтэй нь дийлдэг гэсэн капитализмын хуулиар амьдрах ёстой” гэдэгтэй судалгаанд оролцогчдын зөвхөн 23.7 хувь нь санал нийлж байна гэж хариулжээ.

Бизнес эрхлэгчдийн үзэж байгаагаар хамгийн шударга байгууллагаар (маш шударга, шударга, харьцангуй шударга гэсэн хариулт өгсөн судалгаанд оролцогчдын эзлэх хувийн жингээр нь эрэмбэлж үзэхэд) хувиараа бизнес эрхлэгчид (72.6%), банкны байгууллага (72.3%), олон нийтийн байгууллага (70.2%), ерөнхий боловсролын сургууль (67.3%) зэрэг байгууллага, институциуд орж байгаа бол бизнес эрхлэгчид УИХ-ын гишүүд (33.5%), улс төрийн намууд (35.2%), гаалийн байгууллага (40.9%) зэрэг байгууллагуудыг харьцангуй шударга бус гэж үнэлжээ.

Судалгаанд оролцогчид төрийн үүргийг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Хууль сахиулах (26.7%)
2. Иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах (19.9%)
3. Үйлчлэх (15.4%)

4. Хянах (14.0%)
5. Удирдах (10.7%)
6. Хамгаалах (5.9%)
7. Туслах (5.3%)

2.4. Төрийн албан хаагчдын судалгааны дүн

2.4.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий үзүүлэлтүүд

Төрийн албан хаагчдын дунд явуулсан Авлигын талаарх төсөөллийн судалгаанд 21 аймаг болон нийслэлийн, төрийн захиргааны, төрийн улс төрийн, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албаны 1297 албан хаагч хамрагдлаа. Судалгаанд дунд эргэм насны хүмүүс голчлон оролцсон бөгөөд дундаж нас 37 байв. Тэдний 11.6 хувь нь 25 хүртэл насны, 22.4 хувь нь 26-30 насны, 15.3 хувь нь 31-35 насны, 12.9 хувь нь 36-40 насны, 14.0 хувь нь 41-45 насны, 12.6 хувь нь 46-50 насны, 7.4 хувь нь 51-55 насны, 2.9 хувь нь 56-60 насны, 0.8 хувь нь 61-65 насны, 01 хувь нь 66 болон түүнээс дээш насны төрийн албан хаагчид байв. Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 50.4 хувь нь эрэгтэйчүүд, 49.6 хувь нь эмэгтэйчүүд байв.

Байршлын хувьд судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 20.3 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 73.9 хувь нь аймгийн төвд, 5.8 хувь нь сумын төвд амьдардаг байна.

Судалгаанд хамрагдагсдын 52.2 хувь нь төрийн захиргааны, 31.3 хувь нь төрийн тусгай, 15.4 хувь нь төрийн үйлчилгээний, 1.2 төрийн улс төрийн албан хаагчид байв.

Судалгаанд оролцогчдын төрийн албанд ажилласан дундаж хугацаа 13 жил байгаа нь судалгаанд төрийн албанд харьцангуй олон жил ажилласан, туршлагатай хүмүүс оролцсон болохыг харуулж байна. Судалгаанд оролцогчдын 33.1 хувь нь 5 хүртэл жил, 17.6 хувь нь 6-10 жил, 12.4 хувь нь 11-15 жил, 12.9 хувь нь 16-20 жил, 10.5 хувь нь 21-25 жил, 7.6 хувь нь 26-30 жил, 5.7 хувь нь 31 болон түүнээс дээш жил төрийн албан ажилласан төрийн албан хаагчид байлаа.

Судалгаанд оролцогчдын 7.2 хувь нь 150.0 мянга хүртэл, 60.0 хувь нь 200.0-300.0 мянга, 28.9 хувь нь 300.0-500.0 мянга, 3.9 хувь нь 500.0-700.0 мянган төгрөгийн сарын цалинтай байгаа бөгөөд тэдний сарын дундаж цалин 299.8 мянган төгрөг байна.

Төрийн албан хаагчдын 33.3 хувь нь 2 хүртэл жил, 2.4 хувь нь 3-5 жил, 17.0 хувь нь 6-8 жил, 6.9 хувь нь 9-11 жил тухайн албан тушаал дээрээ ажиллаж байгаа бол үлдсэн 14.3 хувь нь 12 болон түүнээс дээш жилээр тухайн албан тушаалдаа ажиллаж байгаа төрийн албан хаагчид байна.

2.4.2. Төрийн албан хаагчдын амьдралын түвшин

Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын ихэнх нь амьдрал хүнд байна гэсэн дүгнэлтийг хийжээ. Судалгаанд оролцогчдын 65.0 хувь “Олсон орлогоо амьжиргаандаа дөнгөж хүргэж байна”, 15.1 хувь нь “Бүх зүйлээс татгалзаж, зөвхөн хоол хүнсэндээ зарцуулж байна”, 3.7 хувь нь “Заримдаа хоол хүнс хүрэлцэхгүй ядарч байна” гэж хариулсан бол 11.0 хувь нь “Хангалуун амьдарч байна, гэхдээ маш их хөдөлмөрлөж байна”, 1.6 хувь нь “Юугаар ч дутахгүй хангалуун амьдарч байна” гэж хариулжээ.

Судалгаанаас хоёр хүн бүрийн нэг нь ямар нэгэн сэтгэл зовоох зүйлтэй амьдарч байна гэж хариулжээ. “Сүүлийн үед өөрийн сэтгэл санааг Та ямар

байна гэж дүгнэх вэ?” гэсэн асуултад 12.8 хувь нь сэтгэл санаа өөдрөг, өөртэй итгэлтэй байна, 34.5 хувь нь зарим нэг санаа зовох асуудалгүй байгаа ч ерөнхийдөө тайван байна гэсэн өөдрөг хариулт өгсөн бол 39.1 хувь нь зарим нэг юманд санаа зовж байна, 11.5 хувь нь сэтгэл зовж айж байна гэж хариулжээ.

Иргэдийн талаас илүү хувь нь манай улс хөгжлийн зөв бодлоготой явж буй эсэх дээр ямар нэг нэгэн дүнэлтгүй байна. “Манай улс хөгжлийн зөв хандлагатай байна уу эсхүл бид буруу тийш "мухардалд" орж байна уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 50.3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол 32.1 хувь нь “мухардалд”-д орж байна, 17.6 хувь нь зөв хандлагатай байна гэж хариулжээ.

Төрийн үүргийг судалгаанд оролцогчдын 27.9 хувь нь хууль сахиулах, 17.7 хувь нь иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах, 15.0 хувь нь үйлчлэх, 14.2 хувь нь удирдах, 12.2 хувь нь хянах, 6.1 хувь нь хамгаалах, 4.6 хувь нь туслах явдал юм гэж үзжээ.

Үнийн өсөлт (25.8%), ядуурал (16.6%), ажилгүйдэл (9.7%), төрийн албан тушаалтнуудын ашиг хонжоо хайсан байдал, авлига, хүнд суртал (9.1%), хүмүүсийн ёс суртахууны доройтол (7.9%) зэрэг нь манай нийгэмд учирч байгаа, төрийн албан хаагчдын сэтгэлийг хамгийн их зовоосон асуудлууд болж байна. Эндээс харахад бидний судалгааны гол зорилго болох авлига, хүнд суртал, төрийн албан тушаалтнуудын ашиг хонжоо хайсан байдал нь иргэдийн сэтгэлийг зовоож буй асуудлуудын нэг болж байна.

2.4.3. Төрийн албан хаагчдын төрийн албаны талаарх үнэлэмж

“Төрийн албаны тухай” Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5-д “Төрийн алба нь мэргэшсэн тогтвортой байх” зарчмыг хуульчлан баталгаажуулсан бөгөөд сүүлийн үед төрийн албыг цомхон, мэргэшсэн чадварлаг боловсон хүчинтэй байх чиглэлэийг баримталж байгаа билээ. Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 91.6 хувь нь төрийн алба цомхон, мэргэшсэн чадварлаг боловсон хүчинтэй байхыг дэмжиж байгаагаа илэрхийлжээ.

Төрийн албан хаагч болохын тулд шалгалт өгсөн байх ёстой гэдэгтэй судалгаанд оролцогчдын 60.5 хувь нь шууд санал нийлж байгаагаа илэрхийлсэн бол 31.1 хувь нь төрийн албан албан хаагчийг сонгон шалгаруулах шалгалт байдаг хэдий ч төрийн албанд өнөөдөр дуртай хүн нь орж байна, 2.7 хувь нь намайг төрийн албанд ажиллаж эхлэхэд тийм зүйл байгаагүй болоод л байсан гэж үзжээ. Судалгаанд оролцогчдын 4.5 хувь төрийн албан хаагч болохын тулд шалгалт өгсөн байх ёстой гэдэгтэй шууд санал нийлэхгүй байгаагаа илэрхийлсэн байна.

Судалгаанд оролцогчдын 32.1 хувь нь зарлалын дагуу тухайн байгууллагын сонгон шалгаруулалтад орж, зохих шаардлагыг хангасны учир, 23.8 хувь нь өөрөө хөөцөлдөж, зохих журмынх нь дагуу, 21.5 хувь нь сургуулиа төгсөөд тус байгууллагад хуваарилагдан, 12.6 хувь нь тухайн үед төрийн албанд ажиллах сонирхолтой хүн бага байсан учир төрийн орж

байсан гэж хариулжээ. Харин 3.3 хувь нь нэг нутгийн эсвэл найз нөхөд нь оруулж өгсөн эсвэл дарга нь учир ажилд авсан гэж хариулжээ.

Судалгаанд оролцсон төрийн албан хаагчид өөрийн байгууллагын ажилтнуудын бараг ихэнх нь ажлын байрыг өөрийн чадвараар олж авсан гэж 45.3 хувь нь үзсэн бол 15.3 хувь нь бараг тал хувь нь, 19.9 хувь нь маш бага хувь нь ажлын байрыг өөрийн чадвараар олж авсан, 10.0 хувь нь ажлыг байрыг өөрийн чадвараар олж авсан хүн огт байхгүй гэж үзжээ. Хэн нэгэн удирдах албан тушаалтны туслалцаа нөлөөлөөгүй гэж 25.2 хувь, ямар нэг нөлөө бүхий хүн туслаагүй гэж 35.5 хувь, улс төрийн албан тушаалтны нөлөө ороогүй гэж 45.4 хувь, хувийн хэвшил компаниудын зүгээс нөлөөлөөгүй гэж 63.0 хувь нь үзсэн байна.

Хэн нэгнийг ажилд ороход нь тусалдаг гол шалтгаанууд нь судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар гэр бүл, хамаатан садангийн холбоотой учир (23.9%), улс төрийн буюу нэг нам, бүлгийн гэсэн утгаар (21.9), танил тал, найз нөхдийн гуйлтаар (20.3%), нэг нутаг, анги, найз нөхдийн холбоотой (15.7%), өөрт нь ашигтай байсан учир (9.1%) зэрэг шалтгаанууд орж байна.

Хүнд суртал, авлигыг үүсгэх шалтгаан нөхцлүүдийн нэг нь мэдээлэл нээлттэй бус байх явдал юм. Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 39.3 хувь нь тухайн байгууллагын төсвийн төлөвлөлт, төсвийн хэмжээ, зарцуулалтын талаарх мэдээлэл ажилтнуудад нээлттэй байдаг гэж хариулсан бол 52.5 хувь нь удирдлагын шийдвэр, тухайлбал шагнал, урамшуулал, шийтгэл, аж ахуй, гадаад, дотоодын сургалт гэх зэрэг мэдээлэл нээлттэй байдаг гэж хариулжээ.

Улс төрийн нөхцөл байдал буюу сонгуулийн үр дүн, засгийн газар солигдох зэрэг нь төрийн албаны үйл ажиллагаанд ихээхэн нөлөөтэй гэдэгтэй судалгаанд оролцогчдын 62.9 хувь нь санал нийлж байгаа бол 23.0 хувь нь зарим талаараа нөлөөтэй гэж үзжээ.

Төрийн албан хаагчдын 74.4 хувь нь сүүлийн гурван жилийн хугацаанд гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалтад байгууллагынхаа зардал, захиалгаар мэргэжил дээшлүүлээгүй байна. Сургалтад хамрагдаагүй төрийн албан хаагчдын 39.9 хувь нь сургалтад дарга нар л явдаг, 29.7 хувь нь дарга, удирдлын гарын хүмүүс л явдаг, 15.9 хувь нь явъя гэсэн ч явуулдаггүй, 14.5 хувь нь байгууллагын зардлаар сургадаг гэдгийг анх удаа сонсож байна гэж хариулсан байна.

Байгууллагын удирдлагын шийдвэрээр өгсөн шагнал, урамшууллын бараг ихэнх хувь нь ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнгээр бус гадны нөлөөгөөр өгөгдсөн байдаг гэж судалгаанд оролцогчдын 23.5 хувь нь үзсэн бол бараг тал нь гэж 8.9 хувь, маш бага хувь нь гэж 14.3 хувь нь үзжээ. Харин судалгаанд оролцогчдын 26.9 хувь нь ийм төрлийн шийдвэрт гадны нөлөө байдаггүй гэж үзжээ.

Харин төрийн өндөр албан тушаалтны шийдвэрээр өгсөн шагнал, урамшууллын бараг ихэнх хувь нь ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнгээр бус гадны нөлөөгөөр өгөгдсөн байдаг гэж судалгаанд оролцогчдын 5.3 хувь нь үзсэн бол бараг тал нь гэж 5.9 хувь, маш бага хувь нь гэж 15.0 хувь нь үзжээ. Харин судалгаанд оролцогчдын 39.3 хувь нь ийм төрлийн шийдвэрт гадны нөлөө байдаггүй гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын 47.8 хувь нь сахилгын зөрчил гаргасны улмаас, 17.5 хувь нь мэдлэг ур чадвар дутагдаж, 12.3 хувь нь дээд албан тушаалтантай таарахгүй, 5.0 хувь нь тухайн ажлын байранд өндөр албан тушаалтнууд, улс төрийн албан тушаалтнууд өөрийн хүнийг оруулсан, 2.6 хувь нь төсвийн хөрөнгийг шамшигдуулсан эсвэл хээл хахууль авсан, 0.6 хувь нь дээд албан тушаалтантай хамтран хууль бус үйлдэлд оролцохоос татгалзсан зэрэг шалтгаанаар тухайн байгууллагын албан хаагчдаас нь халагдсан гэж хариулсан байна.

Төрийн албан хаагчдын 95.6 хувь нь ажлын байрны тодорхойлолт нь өдөр дутмын ажилд нь тохирсон гэж үзжээ. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 11.7 хувь нь ажлын байрны тодорхойлолтод тусгаснаар үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай эрх мэдэл бараг байхгүй гэж үзсэн бол, 22.8 хувь нь эрх мэдэл бага, 43.2 зарим нэг эрх мэдэлтэй, 22.4 хувь шаардлагатай бүх эрх мэдэл бий гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын 52.2 хувь нь удирдлагатайгаа зөвлөлдсний дараа эцсийн шийдвэр гардаг, 27.8 хувь нь эцсийн шийдвэрийг тухайн албан тушаалтан өөрөө гаргадаг бөгөөд хэрэгжүүлэхээсээ өмнө удирдлагадаа хэсэгчлэн танилцуулдаг, 20.0 хувь нь удирдлагадаа шийдвэр гаргахад нь шаардлагатай мэдээллийг нийлүүлдэг байна.

Ихэнх хүмүүс хувийн секторт ажиллах ажлын нөхцөл сайн байдаг гэж үздэг. Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдаас үүнтэй санал нийлж буй эсэхийг тодруулахад 13.7 хувь нь шууд санал нийлж байгаагаа илэрхийлсэн бол 49.9 хувь нь зарим талаараа санал нийлж байна, 21.7 хувь нь санал нийлэхгүй байна, 14.7 хувь нь мэдэхгүй байна гэж хариулжээ. Тухайн ажилтныг хувийн секторт өөрийнх нь мэргэжил ур чадварын дагуу ажиллахыг санал болговол цалин хөлс, бусад ашигтай талыг харгалзан хамгийн багаар бодоход хэдийн хэмжээний цалин авбал зүйтэй гэж үзэж байна вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 13.2 хувь нь 400.0 хүртэл мянган төгрөг, 34.9 хувь нь 401.0-500.0 мянган төгрөг, 13.6 хувь нь 501.0-700.0 мянган төгрөг, 10.3 хувь нь 701.0-900.0 мянган төгрөг, 21.3 хувь нь 901.0-1000.0 мянган төгрөг, 6.7 хувь нь 1.0 саяас дээш төгрөгийн цалин авахыг хүсч байгаагаа илэрхийлжээ. Төрийн албан хаагчдын хувийн салбарт ажиллаж авахыг хүсч буй цалингийн дундаж хэмжээ 748.3 мянган төгрөг байгаа нь тэдний одоогийн авч буй дундаж цалингаас 2.5 дахин их байна. Төрийн албан хаагчдын хувийн салбарт ажиллаж авахыг хүсч буй цалингийн хамгийн их давтагдаж буй хэмжээ нь 500.0 мянган төгрөг байна.

Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын хувьд цалингаас өөр орлоготой ажилтнуудын эзлэх хувийн жин 9.7 хувьтай байгаа бол 66.2 хувь нь гэр бүлийн гишүүний цалин хөлсөөр гэр бүлийн амьжиргаагаа залгуулдаг, 24.1 хувь нь цалингаас өөр орлогогүй гэж хариулжээ.

Байгууллагын төсвийн зарцуулалтын талаарх мэдээлэл ажилтнуудад нээлттэй байх нь ажилтнууд өөрсдөө байгууллагын удирдлага, ажилтнуудын үйл ажиллагааг хянах нэг хэлбэр юм. Судалгаанд оролцогчдын 63.5 хувь нь өөрийн ажилладаг байгууллагынхаа төсвийн зарцуулалтын талаар мэдээлэлтэй байдаг гэсэн байна.

Төрийн албан хаагчдын 33.7 хувь нь байгууллагынхаа төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авдаг талаар ажилтнууд нь мэддэг гэж хариулсан бол, 31.1 хувь нь зарим тохиолдолд мэддэг, 35.2 хувь нь ерөөсөө мэддэггүй гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 32.5 хувь нь байгууллагаас зарласан төндэрт ялсан этгээд байгууллагын удирдлагатай ямар нэг байдлаар холбоотой гэж үзсэн бол 35.3 хувь нь төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой гэж үзжээ.

Төрийн албан хаагчдын талаас илүү хувь (62%) өөрийн байгууллагыг хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэг гэж үзсэн байна. Харин 3.3 хувь нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чаддаггүй, 31.2 хувь нь зарим нэг зүйл дээр учир дутагдалтай байдаг гэж хариулжээ. Хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаа шалтгааныг 41.5 хувь төсөв хөрөнгө хүрэлцээгүй, 22.1 хувь нь чадварлаг боловсон хүчин дутмаг, 14.1 хувь нь хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөр нь байнга өөрчлөгдөж байдаг, 11.3 хувь улс төрийн нөлөө их байдагтай холбон авч үзсэн бол 10.7 хувь бусад шалтгаантай холбож үзжээ.

Төрийн албан хаагчдын дийлэнх хэсэг буюу нь буюу 78.8 хувь нь өөрийн байгууллагын зүгээс иргэдэд үзүүлж байгаа ажил үйлчилгээнд сэтгэл хангамжтай байдаг байна.

Төрийн албан хаагчдаас авсан энэ удаагийн судалгаанд Засгийн газар, УИХ-ын гишүүд, төрийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг 29 төрлийн институцуудын шударга байдлыг тэднээр үнэлүүлсэн юм.

Тухайн институцийг маш шударга, шударга, харьцангуй шударга гэж хариулсан иргэдийн эзлэх хувийн жингээр эрэмбэлүүлэн авч үзэхэд шударга байдлын үзүүлэлтээр банкны байгууллага (62.9%), олон нийтийн байгууллагууд (62.3%), ерөнхий боловсролын сургуулиуд (59.5%) зэрэг байгууллагууд тэргүүлж байгаа бол гаалийн байгууллага (22.5%), УИХ-ын гишүүд (18.9%), улс төрийн намууд (16.1%) сүүлийн байрыг эзэлжээ.

Төрийн үүргийг судалгаанд оролцогчдын 27.9 хувь нь хууль сахиулах, 17.7 хувь нь иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах, 15.0 хувь нь үйлчлэх, 14.2 хувь нь удирдах, 12.2 хувь нь хянах, 11.2 хувь нь үйлчлэх, 6.1 хувь нь хамгаалах, 4.6 хувь нь туслах явдал юм гэж үзжээ.

2.4.3. Төрийн албан хаагчдын үйл ажиллагаан дахь авлигын тохиолдлууд

Авлига, хүнд суртал, ёсзүйгүй байдалтай холбоотой 10 төрлийн асуудлыг нийт төрийн байгууллагууд болон тухайн ажилтны ажилладаг байгууллагад хэр олон тохиолддогийг судалгаанд оролцогчдоос тодруулсан юм. Танил талаа ашиглах буюу арын хаалга нийт төрийн байгууллагад байнга тохиолддог гэж судалгаанд оролцогчдын 39.1 хувь нь үзэж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бол харин ялгаварлан гадуурхах байдал байнга тохиолддог гэж 13.6 хувь нь хариулсан нь харьцангуй бага давтамжтай үзэгдэл юм гэж дүгнэж болох юм. Ажлын хариуцлагагүй байдал нийт төрийн байгууллагуудад байнга болон хааяа тохиолддог гэж судалгаанд оролцогчдын 92.2 хувь нь үзсэн бол 91.0 хувь нь харилцааны

соёлгүй байдал, 90.4 хувь нь хүнд суртал, 89.4 хувь танил ашиглах байдал, 88.8 хувь нь мэдлэг, чадвар дутмаг албан тушаалтан, 80.0 хувь нь хээл хахууль, 80.5 хувь нь нутгархаж асуудалд хандах, 80.9 хувь нь хууль зөрчсөн үйлдэл, 73.7 хувь нь намын харъяаллаар хэлмэгдүүлэх, 68.5 хувь нь ялгаварлан гадуурхах байдал байнга болон хааяа тохиолддог гэж хариулжээ.

Ажлын хариуцлагагүй байдал тухайн байгууллагад байнга болон хааяа тохиолддог гэж судалгаанд оролцогчдын 76.3 хувь нь үзсэн бол 72.6 хувь нь харилцааны соёлгүй байдал, 68.7 хувь нь мэдлэг чадваргүй албан тушаалтнууд, 66.3 хувь нь танил талаа ашиглах байдал, 59.4 хувь нь хүнд суртал, 46.8 хувь нь нутгархаж асуудалд хандах, 46.2 хувь нь хууль зөрчсөн үйлдэл, 36.7 хувь нь ялгаварлан гадуурхах байдал, 34.0 хувь нь хээл хахууль, 25.4 хувь нь намын харъяаллаар хэлмэгдүүлэх байдал байнга болон хааяа тохиолддог гэж хариулжээ.

Төрийн албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэх явцад нь иргэд үйлчлүүлэгчдийн зүгээс хамгийн их (38.5%) хууль бус санал тавьдаг бол судалгаанд оролцогчдын 30.4 хувь нь найз, нөхдөөс, 22.5 хувь нь дээд албан тушаалтнаас, 15.8 хувь нь улс төрийн нам бүлгийн гишүүдээс, 15.6 хувь нь хамт ажиллагчдаас, 14.7 хувь нь харилцагч байгууллагынхнаас хууль бус санал тавьдаг гэж хариулжээ.

Түүнчлэн төрийн албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэх явцад нь дээд албан тушаалтны зүгээс хамгийн их (26.5%) дарамт шахалт ирдэг бол судалгаанд оролцогчдын 21.7 хувь нь иргэд үйлчлүүлэгчдийн зүгээс, 15.5 хувь нь улс төрийн нам бүлгийн гишүүдээс, 10.6 хувь нь хамт ажиллагчдаас, 9.6 хувь нь харилцагч байгууллагынхнаас, 9.4 хувь нь найз, нөхдийн зүгээс дарамт шахалт үзүүлдэг гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 36.4 хувь нь төрийн албан тушаалтантай ажил үүрэгтэй нь холбоотой асуудлаар харьцаж ажиллах шаардлага гарахад хуулийн дагуу хөөцөлдөх, 36.0 хувь нь хариуцсан албан тушаалтантай нь нүүр тулж уулзах, 14.8 хувь нь асуудлыг шийдэх эрх бүхий хүмүүст хуулийн дагуу ажиллахыг шаардаж ойлгуулах, 6.7 хувь нь танил хүнийг нь олох, 4.2 хувь нь дээрээс нь даргаар нь нөлөөлүүлэх, 1.9 хувь бусад аргыг хэрэглэнэ гэжээ.

Төрийн албан хаагчдын 38.9 хувь нь төрийн бусад ажил үйлчилгээ авах үед үүссэн асуудал бэрхшээлийг даван туулахын тулд төрийн албан хаагчийн гарыг хүндрүүлэх хэрэг гардаг гэж хариулжээ. Гар хүндрүүлэх хэрэг гардаг тохиолдолд тэр санааг зуучлагч бусад хүмүүс гаргадаг гэж 17.8 хувь нь хариулсан бол 16.6 хувь нь таньдаг хүмүүс, 12.3 хувь өөрөө, 10.9 хувь нь төрийн ажил үйлчилгээ авч буй хүн, 2.2 хувь нь ажлын газрынхан уг саналыг гаргадаг, 6.4 хувь нь тогтсон тариф байдаг тул шууд л өгч авалцдаг гэж хариулжээ.

Төрийн бусад ажил үйлчилгээ авах үед үүссэн асуудал бэрхшээлийг даван туулахын тулд төрийн албан хаагчийн гарыг хүндрүүлдэг зүйлийн дундаж хэмжээ 463.0 мянган төгрөг байдаг байна (жигнэсэн дунджаар тооцож үзэхэд). Төрийн албан хаагчдад хээл хахууль өгч асуудлаа шийдвэрлүүлдэг гэж хариулсан хүмүүсийн 42.1 хувь нь 50.0 хүртэл мянган

төгрөг, 21.7 хувь нь 50.0-100.0 мянган төгрөг, 23.7 хувь нь 100.0-500.0 мянган төгрөг, 12.5 хувь нь 500.0 мянга төгрөгөөс дээш төгрөгийн хахууль өгдөг байна.

Нөгөө талаас судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 11.3 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд өөрт нь хээл хахууль өгөх гэсэн оролдлого гарч байсан гэж хариулсан бөгөөд тэдний 42.3 хувьд нь нэг удаа, 26.9 хувьд нь хоёр удаа, 7.7 хувьд нь гурваас таван удаа энэ тохиолдол тулгарч байсан бол 23.1 хувь нь яг хэд гэдгийг нь сайн санахгүй байна гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчид дунджаар сарын дундаж цалингаас 54.4 хувиар илүү хэмжээний мөнгийг төрийн албан хаагчдад хээл хахууль хэлбэрээр өгдөг гэсэн дүн гарч байна.

2.4.4. Авлигын тодорхойлолт, цар хүрээ, хэлбэр шалтгааны талаарх төрийн албан хаагчдын төсөөлөл

Энэ удаагийн судалгаагаар бид бүхэн төрийн албан хаагчид авлигыг хэрхэн тодорхойлж байна вэ гэдгийг тодруулах зорилго бүхий асуултыг оруулсан юм. Төрийн албан хаагчид авлигыг хэрхэн ойлгож байна вэ гэдгийг тодорхойлох нь уг үзэгдлийг судлахад болон соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Төрийн албан хаагчдын зүгээс харьцангуй олон санал авсан тодорхойлолтууд нь “Улс төрч, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчид нэгдэн нэг бүлэг болж иргэд, улс эх орныхоо төлөө бус зөвхөн өөрсдийн төлөө үйл ажиллагаа явуулах” (16.4%), “Төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрчид өөрийн албан тушаалыг ашиг хонжоо олох зорилгоор ашиглах” (15.6%), “Өөрсөддөө ашигтай шийдвэр гаргуулахын тулд том бизнес эрхлэгчид төрийн өндөр албан тушаалтнуудыг өөрийн талд оруулах” (15.5%), “Төрийн албан хаагчид иргэдээс хээл хахууль авах” (10.8%) зэрэг байлаа.

Судалгаанд оролцогчдын 77.4 хувь нь өөрийн ажлын байрыг авлигад өртөмтгий биш гэж үзсэн бол 8.5 хувь нь өртөмтгий, 14.1 хувь байдлаас шалтгаална гэж хариулжээ. Авлигатай холбоотой асуудалд судалгаанд оролцогчдын 55.7 хувь нь авлигатай холбоотой асуудлыг ерөөсөө сонирхдоггүй, 22.3 хувь нь үл тэвчдэг, 7.2 хувь нь тухайн байдлаас болно, 3.6 хувь нь байх л зүйл гэж үзсэн бол 11.2 хувь хариулахад хүндрэлтэй байна гэжээ.

Төрийн байгууллагууд болон бусад институцийн хувьд авлигад хэр автсныг судалгаанд оролцогчдоор тодорхойлуулан авлигад харьцангуй их автсан, нэлээд автсан гэж үзсэн иргэдийн дүнгээр авч үзэхэд эхний таван байранд газрын алба (82.6%), эмнэлэгүүд (80.9%), гаалийн байгууллага (80.1%), мэргэжлийн хяналтын байгууллага (77.6%), их дээд сургуулиуд (76.4%) оржээ. Авлигад харьцангуй автаагүй институцээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид (56.1%), олон нийтийн байгууллагууд (48.5%) орж байна.

Сүүлийн гурван жилийн хугацаанд тухайн аймаг, нийслэл, дүүрэгт авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн талаарх асуултад төрийн албан хаагчдын 22.5 хувь нь өссөн, 16.8 хувь нь өөрчлөгдөөгүй гэж үзсэн бол ердөө 8.2 хувь нь буурсан гэж хариулжээ. Авлигын түвшин хэрхэн

өөрчлөгдсөн талаар төрийн албан хаагчдын талаас илүү хувь нь ямар нэг төсөөлөлгүй байна. Дараагийн гурван жилд хэрхэн өөрчлөгдөх талаарх иргэдийн үзэл бодлыг өмнөх гурван жилийн талаарх төсөөлөлтэй харьцуулахад өснө гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 4.9 пунктээр өссөн гэж үзсэн иргэдийн эзлэх хувиас бага байна. Иргэдийн 17.6 хувь нь өснө, 20.0 хувь нь өөрчлөгдөхгүй гэж үзсэн бол 15.5 хувь нь буурна гэж үзжээ.

Төрийн албан хаагчид өөрийн байгууллагын удирдлагыг илүү их авлигын эсрэг хангалттай тэмцэж байна гэж үзэж байна. Өөрийн байгууллагын удирдлагыг авлигатай тэмцэх чиглэлээр судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 26.0 хувь нь хангалттай, 29.3 хувь нь дунд зэрэг ажиллаж байна гэж дүгнэжээ.

Харин Авлигатай тэмцэх газрыг судалгаанд оролцогчдын 17.8 хувь нь хангалттай, 36.8 хувь нь дунд зэрэг, 27.2 хувь нь хангалтгүй ажиллаж байна гэж үзсэн бол 18.2 хувь нь мэдэхгүй байна гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 9.3 хувь нь Авлигатай тэмцэх гэзрын үйл ажиллагааг хангалттай мэддэг гэсэн бол 43.6 хувь нь дунд зэрэг, 19.5 хувь нь хангалтгүй, 27.5 хувь нь мэдэхгүй гэжээ. Харин авлигын эсрэг хуулийг 16.3 хувь нь хангалттай, 47.1 хувь дунд зэрэг мэддэг, 20.2 хувь нь хангалтгүй, 16.3 хувь нь мэддэггүй байна.

Төрийн албан хаагчдын олонх буюу 69.8 хувь төрийн албан хөөгчийн ёс зүйг хангалттай мэддэг гэж хариулсан байна.

Энэ удаагийн судалгаагаар авлига үүсгэх шалтгаан нөхцөл болж болох 26 асуудлыг тавьж эдгээр нь авлига үүсэх чухал нөлөөтэй эсэхийг тодруулсан юм. Эдгээр асуудлыг чухал гэж үзсэн хүмүүсийн эзлэх хувиар нь эрэмбэлж үзвэл Төрийн албан хаагчдын цалин нь амьдралд нь хүрэлцдэггүй (79.4%), төрийн хяналтын систем сул (74.8%), томоохон бизнес эрхлэгчид төрд нөлөөлөх (73.9%) зэрэг шалтгаан нөхцлүүд тэргүүлж байгаа бол нөгөө талаар албан тушаалтнуудын үйл ажиллагаа заавар, журмаар муу зохицуулагдсан (46.1%), дэндүү их заавар, дүрэм, журам байдаг (44.4%), түүхэн талаас нь авч үзвэл авлига нь Монголчуудын амьдралын хэв шинжийн нэг хэсэг болж ирсэн (27.7%) зэрэг шалтгаан нөхцлүүд жагсаалтын сүүлийн байруудыг эзэлжээ (Шалтгаан нөхцөл тус бүрээр хариултыг хавсралт хүснэгтээс үзнэ үү).

Авлига авсан албан тушаалтан шүүх хурал дээр өөрийгөө хэрхэн зөвтгөж болох вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 26.4 хувь нь “Манай цалин бага, би гэр бүлээ тэжээх хэрэгтэй байна шүү дээ”, 24.4 хувь нь “Баригдаж мэдэгдсэн нь л би болохоос бүгд авч байгаа шүү дээ”, 7.9 хувь нь “Би өөрийн хүсэлтээр хахууль аваагүй, дарга нарын шахалтаар л хийсэн шүү дээ”, 7.4 хувь нь “Манай удирдлага аваад байхад би яагаад авч болохгүй гэж”, 7.2 хувь нь “Надад маргааш юу болохыг мэдэхгүй. Би ирээдүйн талаар бодох хэрэгтэй”, 4.3 хувь нь “Би их удаан ажиллаж байгаа, мэргэшсэн, гэтэл намайг одоо болтол дэвшүүлэхгүй байна” гэж хэлж болох юм гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын 54.1 хувь нь даргаа авлига авдаг талаар сонсоод мэдээлэл бичиж өгсөн хүнийг үнэнч шударга хүн гэж тодорхойлно

гэж хариулсан бол 1.8 хувь нь баатар гэж үзэж, 15.9 хувь нь мангар, өшөө авагч, атаархагч, урвагч гэж тодорхойлжээ.

Манай улсын авлигыг үгүй болгох стратегийг боловсруулах боломж олдвол дараах зүйлүүдээс алийг нь авч хэрэгжүүлэх вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 43.1 хувь нь авлигыг бий болгож буй нөхцлүүдийг эрхзүйн, эдийн засгийн гэх мэт хүрээнд үгүй болгох хэрэгтэй, 34.1 хувь нь шударга бус удирдагчдыг шударга удирдагчдаар солих, 13.0 хувь нь авлигач нарыг шийтгэж байх шаардлагатай, 7.4 хувь нь авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагааг эрчимтэй, тогтмол хийх хэрэгтэй гэж хариулсан бол 1.3 хувь нь ямар ч стратеги шаардлагагүй, авлигатай тэмцэх нь үр дүн байхгүй гэж үзжээ.

Бүлэг 3. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

3.1 Судалгааны үр дүнгээс хийсэн дүгнэлт

Авлигын ерөнхий төлөв байдлын энэ удаагийн судалгааны зорилго нь иргэд, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчдийн авлигын талаарх төсөөлөл, авлигын цар хүрээ, хэлбэр шалтгаан, тэдгээрийг хэрхэн арилгах талаарх тэдний санаа бодлыг тодруулах, авлигатай холбоотой тэдэнтэй тохиолдож байсан асуудлууд, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэж байсан зэрэг мэдээллийг цуглуулан, нэгтгэн дүгнэж олон нийтэд тархаах, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийн суурь мэдээлэл болгон ашиглах явдал байсан юм. Нөгөө талаас авлигын индексийн аргачлалыг боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, энэ чиглэлээр судалгаа явуулах туршлага хуримтлуулахад энэ удаагийн судалгааны зорилго оршиж байсан юм.

Авлигын ерөнхий төлөв байдлын 2008 оны судалгааг 21 аймаг, нийслэлийн 2990 иргэд, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчдыг хамруулан явуулж, үр дүнг нэгтгэн гаргасан нь дээрх зорилгуудыг бүрэн хангаж чадсан үйл ажиллагаа боллоо гэж дүгнэж байна.

Авлига, хүнд суртал, төрийн албан тушаалтнуудын ашиг хонжоо хайсан байдал нь иргэдийн сэтгэлийг зовоож буй асуудлуудын нэг болж байгаа бөгөөд үнийн өсөлт, ядуурал, ажилгүйдлийн дараа орж байна. Иймээс энэ чиглэлд анхаарлаа хандуулж, авлигын цар хүрээ, шалтгаан нөхцлийг тодорхойлон судалгаа мэдээлэлтэйгээр, системтэйгээр энэхүү үзэгдэлтэй тэмцэх нь зүйтэй юм.

Авлигын цар хүрээг тодорхойлох явдал нь энэ удаагийн судалгааны эхний зорилго байсан юм. Судалгаанд оролцогчдын төсөөллөөр манай улсад авлига түгээмэл үзэгдэл болоод байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 81.9-87.7 хувь нь манай улсад авлига газар авсан гэж дүгнэжээ. Гэхдээ авлигын цар хүрээний талаарх иргэдийн төсөөлөл нь ихээхэн субъектив шинж чанартай гэж үзэх хандлага байдаг. Судалгаанд оролцсон иргэдийн 81.9 хувь авлига түгээмэл үзэгдэл гэж үзсэн хэдий ч тэдний 57.5 хувь нь өөрийн болон гэр бүлийнхээ гишүүдийн асуудлыг шийдвэрлүүлэхээр төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулжээ.

Олон нийт авлигыг хэрхэн ойлгож байна вэ гэдгийг тодруулах нь уг үзэгдлийг судлахад чухал холбогдолтой юм. Авлигыг иргэд олон янзаар тодорхойлж байгаа хэдий ч төрийн албан тушаалын эрх мэдлээр бизнес хийх гэсэн тодорхойлолт давамгайлж байна. Түүнчлэн авлигыг хээл хахууль өгөх, авах гэдгээр голчлон ойлгож, албан тушаалаа урвуулан ашиглаж төсвийн хөрөнгийг шамшигдуулах, өөрийн эрх ашигт нийцүүлэн шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулах зэргийг орхигдуулах хандлага байгааг энд дурьдах нь зүйтэй юм. Үүнтэй холбоотойгоор “авлига өгөх”, “авлига авах” гэсэн буруу ойлголт олон нийтийн дунд бий болсон байна. Дээр дурьдсан

хоёр тооны зөрүүгээр авлига болон хээл хахуулийн хоорондын ялгааг харуулж байна гэж үзэж болох юм.

Иргэдийн зүгээс төрийн албан хаагчдад хээл хахууль өгөх санаачлага, шалтгаан нь ерөнхийдөө тухайн асуудлыг хээл хахууль өгөхгүйгээр шийдвэрлэх боломжгүй гэсэн тогтсон үзэл баримтлал байдаг, иргэд өөрсдөө хээл хахуулийг санал болгож өгдөг, төрийн албан хаагчид шаарддаг эсвэл тийм байдалд оруулдаг гэсэн гурван эх үүсвэртэй байдаг байна. Судалгааны дүнгээр иргэд дунджаар 520.9 мянган төгрөгийн хэмжээтэй хээл хахуулийг дунджаар 210 хоногийн хугацааны дотор төрийн албан хаагчдад өгсөн байна. Иргэдийн төрийн албан хаагчдад өгсөн хахуулийн хэмжээ нь тэдний сарын дундаж орлогоос 47.3 хувиар илүү байгаа юм.

Иргэд, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчдын төсөөллөөр авлигад хамгийн их өртсөн институциудээр газрын алба, УИХ-ын гишүүд, гаалийн байгууллага, эмнэлэгүүд, улс төрийн намууд зэргийг нэрлэж байна.

Судалгаанд оролцогчид улс төрчид, төрийн албан тушаалтнуудын ёс зүйгүй байдал болон төрийн хяналтын систем сул байгаа нь авлигыг бий болгож буй гол хүчин зүйл гэж үзэж байна. Харин бусад шалтгаан нөхцөлүүдийн хувьд иргэд, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид бүр ялгаатай байдлаар тодорхойлж байна. Тухайлбал, авлига үүсэх шалтгаан нөхцөл болж болох 26 асуудлаас иргэд төрийн хяналтын систем сул байгааг, төрийн албан хаагчид төрийн албан хаагчдын цалин амьдралд нь хүрэлцдэггүй байдлыг, бизнес эрхлэгчид төрийн үйл ажиллагаа бизнесийн үйл ажиллагаатай холилдож байгаа зэргийг авлига үүсэхэд чухал нөлөөтэй хүчин зүйл гэж үзэж байна.

Судалгааны дүнгээс авлигыг гол нөхцөл нь улс төрийн тогтолцоо, сонгуулийн системд байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 57.0-68.7 хувь нь улс төрийн намууд, УИХ-ын гишүүдийг авлигад их автсан, 82.5 хувь нь улс төрчид авлигаас ашиг хонжоо олдог учраас авлигатай тэмцэх хүсэл зорилго байдаггүй, 79.3 хувь нь өөрсдөд нь ашигтай байдаг учраас бизнес эрхлэгчид төр засгийн хүрээнд авлигачдыг байлгах сонирхолтой байдаг гэж үзсэн зэрэг үүнийг баталж байгаа юм. Бизнес эрхлэгчид ашиг хонжоо хайж улс төрд, цаашлаад төрийн албанд ордог, түүнчлэн бизнес эрхлэгчид өөрийн бизнесийн үйл ажиллагааг дэмжүүлэхийн тулд улс төрчид, төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлдэг байна. Тэгэхээр улс төрийн намын болон сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн асуудалд анхаарлаа хандуулж ажиллах цаг нэгэнт болсныг дээрх бүх нөхцөл байдлууд харуулж байна.

Олон нийт авлигатай тэмцэх үйл ажиллагааны эхлэлийн цэг нь авлига үүсэх нөхцлийг эрх зүйн, эдийн засаг гэх мэт бүх хүрээнд үгүй болгох үйл ажиллагаа байх ёстой гэж үзэж байна.

Олон нийтийн авлигын талаарх мэдээллийг олж авдаг гол хэрэгсэл нь сонин болон телевиз болдог байна. Иймээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх энэ төрлийн мэдээллийг ашиглан хийх нь үр дүнгээ өгөх юм.

3.2 Судалгааны үр дүнд үндэслэн дэвшүүлж буй санал, зөвлөмжүүд

Авлигын ерөнхий төлөв байдлын энэ удаагийн судалгааны үр дүнд үндэслэн дараахь санал зөвлөмжүүдийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Авлигын тархацын талаарх олон нийтийн төсөөллийг авлигыг хэмжих хэмжүүр болох Авлигын индексийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх. Авлигын тархацын талаарх олон нийтийн төсөөлөл нь авилгын цар хүрээг үнэн бодитой харуулж чадахгүй боловч нөгөө талаар урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрсэн үр дүнг үнэлэх нэг шалгуур үзүүлэлт болох юм.
2. Цаашид авлигын ерөнхий төлөв байдлын судалгааны аргачлал арга зүйг сайжруулан тогтмол хугацааны давтамжтайгаар явуулах. Энэ төрлийн судалгаа нь авлигын ерөнхий төлөв байдал, олон нийтийн хандлагыг тодорхойлох нэг гол мэдээллийн эх үүсвэр юм.
3. Авлигын цар хүрээ, хэмжээ, хэлбэр шалтгааны талаар тооцоо судалгаанд үндэслэсэн илүү бодитой мэдээллийг олон нийтэд тархаах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тархааж мэдээлэлд үнэлэлт дүгнэлт өгч байх. Авлигын талаарх бодитой бус, тооцоо судалгаанд үндэслээгүй таамаг төдий мэдээлэл нь авлигын талаарх олон нийтийн төсөөлөлд нөлөөлж, энэ байдалд эргээд авлига бол түгээмэл үзэгдэл, хээл хахууль өгөхгүйгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй гэсэн үзэл баримтлалыг олон нийтийн дунд дэлгэрүүлэхэд хүргэж байна.
4. Авлигыг үүсгэж буй шалтгаан нөхцөлүүдийг эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд судлан үзэж, тэдгээрийг арилгах талаар системтэй бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. Авлигыг үүсгэж буй шалтгаан нөхцөлүүдийг салбар, чиглэл тус бүрээр судлан үзэж үнэлэлт дүгнэлт өгөх ажил нэн тэргүүнд төрийн байгууллагуудын авлигын эрсдлийн үнэлгээгээр хэрэгжих юм гэж үзэж байна.
5. Авлигын эдийн засаг, нийгэмд учруулж буй хор хөнөөлийн талаар таамгийн төдий бус үндэслэл, тооцоотой судалгааг хийж олон нийт, бодлого боловсруулагчдад тархаах. Авлигын хор хөнөөлийн талаар олон төрлийн судалгаа байдаг боловч тэдгээр нь онолын шинж чанартай, таамаг төдий мэдээллүүд байгаад дүгнэлт хийж бодитой тоо мэдээллээр баталгаажуулсан, үндэслэл, тооцоо судалгаа хийх зайлшгүй шаардлагатай байна.
6. Авлигыг үүсгэж буй голлох шалтгааны нэг нь улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй, ил тод нээлттэй болгох. Сонгуулийн сурталчилгаа болон бусад үйл ажиллагаанд иргэд, бизнес эрхлэгчдээс хандив, дэмжлэг авах, эргээд дэмжлэг үзүүлсэн этгээддээ ашигтай байдал бий болгох нь нийтлэг үзэгдэл болж байна.
7. Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үзэл баримтлал, бодлого хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх. Авлигыг үл тэвчих уур амьсгалыг бий болгох, авлигатай холбоотой мэдээллийг олон нийтэд тархаах үйл ажиллагаа нь ямар нэг үзэл баримтлал, бодлогогүй явж байгаад дүгнэлт хийх хэрэгтэй байна.

Олон нийтийн төсөөллөөр авлигын түвшин өндөр байгаа нь соён гэгээрүүлэх үйл ажиллагаатай дам холбоотой юм.

8. Авлигын тодорхойлолтыг нэг мөр болгож хэвшүүлэх, хуулийн нэр томъёог энгийн ойлгомжтой байдлаар тайлбарлаж соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах.

Товчилсон үгсийн жагсаалт

АТГ	Авлигатай тэмцэх газар
США	Судалгаа шинжилгээний алба
УИХ	Улсын их хурал
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
АНУ	Америкийн нэгдсэн улс

Авлигын ерөнхий төлөв байдлын судалгааны тайланг уншиж танилцсан танд баярлалаа. Судалгааны мэдээлэлтэй холбоотой асуулт, санал зөвлөмж байвал Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албанд хандахыг хүсье.

Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний алба:

Смарт Булдингийн 401 тоот.

Сөүлийн гудамж,

Сүхбаатар дүүрэг,

Улаанбаатар хот,

Монгол улс.

Утас: 976-70112565

email: davaasuren@iaac.mn

Авлигатай тэмцэж, шударга ёсыг тогтоон хөгжил дэвшилд хүрцгээе.